



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР



ЭРДЭМ
СУРГАЛТ СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ 2022

Монгол Улсын Засгийн газрын
тохируулагч агентлаг Хил хамгаалах
ерөнхий газрын захиалгаар “Эрдэм
сургалт судалгааны хүрээлэн” ТББ
боловсруулан гүйцэтгэв

Улаанбаатар хот
2022 он

Хил хамгаалах ерөнхий газрын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа 2022

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	ii
Зургийн жагсаалт	iii
Графикийн жагсаалт	iv
Хүснэгтийн жагсаалт	v
Удиртгал	1
Судалгааны үндэслэл	1
Судалгааны арга зүй	2
Нэг. ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХУУЛЬД ЗААСАН НИЙТЛЭГ БОЛОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ	4
1.1. Хил хамгаалах ерөнхий газрын нийтлэг чиг үүрэг	6
1.1.1. Эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр олон нийтэд чиглэсэн ажил үйлчилгээ	6
1.1.2. Мэдээллийн ил тод байдал, хүртээмж	7
1.1.3. Иргэний шаардах эрхийн баталгаа: өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байдал	17
1.1.4. Үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжид үйлчлүүлэгчдийн өгсөн үнэлгээ	18
1.2. Хил хамгаалах ерөнхий газрын тусгай чиг үүрэг:	23
1.2.1. Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ	23
1.2.2. Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ	25
1.2.3. Хилийн зурваст нэвтрэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ	28
Хоёр. ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА	31
2.1. Алба хаагчийн ажиллах нөхцөл, нийгэм, эдийн засгийн баталгаа	31
2.2. ХХЕГ-аас үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тойм	31
ДҮГНЭЛТ	35
ЗӨВЛӨМЖ	36
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	38

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
МУЗН	Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг
ОХУ	Оросын Холбооны Улс
ХЗДХ-ийн Сайд	Хууль зүй, дотоод хэргийн Сайд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХБ	Хил хамгаалах байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХШН боомт	Хилийн шалган нэвтрүүлэх боомт

Зургийн жагсаалт

Зураг 1. Хилийн цэргийн тусгай архивын онлайн захиалгын хуудас	9
Зураг 2. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аас авах боломжтой Хил хамгаалах ерөнхий газрын үйлчилгээнүүд	9
Зураг 3. ХХЕГ-ын албан ёсны вебсайтад 2022 онд байрлуулсан видео контентууд.....	11
Зураг 4. “Хил хамгаалах байгууллага” фэйсбүүк хуудас	12
Зураг 5. Хөшигийн хөндий нисэх буудал дахь хилийн шалган нэвтрүүлэх хэсэг 2022.12.19	23
Зураг 6. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аас Улсын хилээр нэвтэрсэн иргэний лавлагаа авах үйлчилгээ	25
Зураг 7. Алтанбулаг боомтын барилгын ажлын явц 2022.12.16.....	26
Зураг 8. Алтанбулаг чөлөөт бүс дэх хилийн шалган нэвтрүүлэх хэсэг 2022.12.17	26
Зураг 9. Алтанбулаг боомтын үйлчилгээний талбай 2022.12.16	26
Зураг 11. Алтанбулаг боомтын зорчигч шалган нэвтрүүлэх хэсэг 2022.12.17.....	26

Графикийн жагсаалт

График 1. Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ) болон хилийн боомтын талаарх мэдээллийг голлон авч буй мэдээллийн суваг	13
График 2. ХХЕГ ба хилийн боомтын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, нээлттэй, ил тод эсэх	14
График 3. Хил хамгаалах ерөнхий газрын цахим хуудаст зочилж байсан байдал	14
График 4. Хил хамгаалах ерөнхий газрын цахим хуудаст зочилж хэрэгтэй мэдээллээ авч чадсан эсэх	15
График 5. Хил хамгаалах ерөнхий газартай утсаар холбогдсон байдал	15
График 6. Хил хамгаалах ерөнхий газартай утсаар холбогдож хэрэгтэй мэдээллээ авч чадсан эсэх	15
График 7. Үйлчлүүлэгчид мэдээлэл өгч буй хэлбэрийг үнэлсэн байдал	16
График 8. Судалгаанд оролцогчдын байршил	18
График 9. Судалгаанд оролцогчдын нас, хүйс	18
График 10. Судалгаанд оролцогчдын боловсрол, ажил эрхлэлт	19
График 11. Судалгаанд оролцогчдын авсан үйлчилгээний төрөл болон иргэн болон ААНБ-ын төлөөллийн харьцаа	19
График 12. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд ХХБ-аар үйлчлүүлсэн эсэх	20
График 13. ХХЕГ-аас үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээл гарсан эсэх, Хилийн зурваст үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад ХХБ-аас шалтгаалсан хүндрэл бэрхшээл тохиолдсон эсэх	20
График 14. ХХБ-ын алба хаагчийн ёс зүй, ур чадварт өгч буй үнэлгээ	20
График 15. ХХЕГ-аас үйлчилгээ авахад зарцуулж буй хугацаа	21
График 16. ХХБ-ын үйлчилгээний шат дамжлага, түргэн шуурхай байдалд өгч буй үнэлгээ	21
График 17. ХХБ-ын үйлчилгээний хүртээмжтэй, ойлгомжтой байдалд өгч буй үнэлгээ	22
График 18. ХХБ-ын үйлчилгээ илүү сайжирч байгаа гэдэгтэй санал нийлж буй эсэх	22

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Асуулга судалгаанд хамрагдсан ХХБ-аар үйлчлүүлэгч иргэн (n=191) ба зөвшөөрөл авсан ААНБ-ын (n=22) тоо	2
Хүснэгт 2. Ганцаарчилсан ярилцлагад хамруулах төрийн байгууллага болон ХХЕГ-ын холбогдох мэргэжилтний тоо (n=54)	2
Хүснэгт 3. Хил хамгаалах байгууллагын 2020-2022 оны 12 сарын 06-ны өдрийн байдлаар Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн талаар гаргаж өгсөн лавлагаа, мэдээллийн тоо.....	24
Хүснэгт 4. Хилийн боомтод үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагад олгосон зөвшөөрөл нэвтрэх үнэмлэхийн судалгаа	27

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Хууль зүй, дотоод хэргийн яам, харьяа агентлаг, байгууллага нь чиг үүргийн дагуу иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлэхдээ Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан хүний эрх, шударга ёс, тэгш байдлыг ханган ажиллах үүрэг хүлээдэг.

Салбарын байгууллагын үйлчилгээний талаар иргэд, байгууллагын сэтгэл ханамжийн байдлыг үнэлэх, тодруулбал Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа агентлаг, байгууллага иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээ тэгш, хүртээмжтэй, чанартай, хүний эрхийг хүндэтгэсэн, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэд, байгууллагын сэтгэл ханамж, хандлагыг үнэлэх нь чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баталж, дээрх байгууллагуудаас тухайн жилд хэрэгжүүлсэн зорилтуудын биелэлт, үр нөлөөний талаар хэрэглэгчийн үнэлгээг жил бүр хийн ажиллахаар тусгажээ. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын үүрэг болгосны дагуу тус яамны төрийн нарийн бичгийн даргын баталсан Хууль зүй, дотоод хэргийн яам түүний харьяа агентлаг, байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг үйлчилгээнд хөндлөнгийн судалгаа /хяналт үнэлгээ/ хийлгэх ажлын удирдамжаар Засгийн газрын Тохируулагч агентлаг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Хил хамгаалах ерөнхий газрын хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээнд хэрэглэгчийн үнэлгээ судалгааг гүйцэтгэлээ.

Зорилго, зорилт

Хил хамгаалах ерөнхий газрын хуулиар олгогдсон чиг үүргийн дагуу иргэн, ААНБ-д үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийхэд чиглэнэ. Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

1. 2022 оны байдлаар ХХЕГ-т ирүүлсэн санал, өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийх;
2. ХХЕГ-ын Монгол Улсын Хилийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд төрөөс анхаарах шаардлагатай асуудал болон зайлшгүй өөрчлөлт хийх эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх /Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хил орчмын бүс нутагт харилцах зорчих хэлэлцээр, хилийн дэглэмийн гэрээ гэх мэт/;
3. ХХЕГ-ын хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжийн бодит байдлыг үйлчилгээг хүртэгч иргэд, байгууллагын санаа бодол, сэтгэл ханамжид тулгуурлан хэрэглэгчийн үнэлгээний арга зүйгээр тандан судлах;
4. ХХЕГ-ын хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйл ажиллагаа, үйлчилгээнд цаашид анхаарах асуудал, сайжруулах арга замыг тодорхойлох зэрэг болно.

Судалгааны арга зүй

ХХЕГ-ын хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн, шуурхай байдлыг үнэлэхдээ асуулга, ганцаарчилсан ярилцлагын аргыг хэрэглэв. Тодруулбал, ХХЕГ-аар үйлчлүүлэгч иргэн, байгууллагаас асуулгын аргаар, ХХЕГ болон тус байгууллагатай хамтарч ажилладаг байгууллагын төлөөллөөс ганцаарчилсан ярилцлагын аргаар тоон болон чанарын мэдээлэл цуглуулж нэгтгэн дүгнэлээ.

1. Баримт бичиг боловсруулалтын арга. Хил хамгаалах байгууллагын хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөж буй хэм хэмжээний акт, тэдгээрийн хэрэгжилт, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу үйлчлүүлэгчид чиглэсэн ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг байгууллагын тайлан мэдээтэй харьцуулан үнэлэх зорилгоор тус аргыг ашигласан болно.

2. Асуулгын арга. Урьдчилан боловсруулсан асуулгын хуудсаар ХХЕГ-аар үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээдийг хамруулан тус байгууллагын хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмж болон үйл ажиллагаанд анхаарах асуудал, саналуудыг тодорхойлсон тоон мэдээллийг цуглууллаа. Асуулга судалгаанд Улаанбаатар хотод байрлах ХХЕГ болон Хөшигийн хөндийн агаарын замын Буянт-Ухаа олон улсын хилийн, Сэлэнгэ аймаг дахь авто замын Алтанбулаг олон улсын хилийн боомтоор үйлчлүүлсэн нийт 191 иргэн, 22 ААНБ-ыг хамруулав. Хүснэгт 1.1-т асуулга судалгааны түүврийн мэдээллийг харууллаа.

3. Ганцаарчилсан ярилцлагын арга. ХХЕГ-ын ажилтан, алба хаагч, тус байгууллагатай хамтран ажилладаг төрийн байгууллагын төлөөллийг хамруулсан ганцаарчилсан ярилцлагыг зохион байгууллаа. Орон нутагт хийсэн ганцаарчилсан ярилцлагад хилийн боомтын холбогдох ажилтан, алба хаагч, албан тушаалтан болон Хөшигийн хөндийн агаарын замын Буянт-Ухаа олон улсын хилийн, Сэлэнгэ аймаг дахь авто замын Алтанбулаг олон улсын хилийн боомт дахь хилийн шалган нэвтрүүлэх байгууллагын төлөөллийг оролцуулан үнэлгээний зорилгод чиглэсэн мэдээллийг цуглууллаа. Хүснэгт 1-т ганцаарчилсан ярилцлагад хамруулах оролцогч талуудын тоон мэдээллийг үзүүлэв.

Хамрах хүрээ, түүвэрлэлт. Хэрэглэгчийн үнэлгээ судалгаанд ХХЕГ-аар үйлчлүүлэгч нийт 191 иргэн, 22 ААНБ-ын төлөөллийг санамсаргүй түүвэрлэлтийн арга техникээр хамруулсан ба судалгаанд хэрэглэсэн арга тус бүрээр нь дараах түүвэрлэлтийн хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Асуулга судалгаанд хамрагдсан ХХБ-аар үйлчлүүлэгч иргэн (n=191) ба зөвшөөрөл авсан ААНБ-ын (n=22) тоо

Судалгааны талбар	Иргэн	ААНБ
Хөшигийн хөндийн агаарын замын Буянт-Ухаа олон улсын хилийн боомт	106	8
Сэлэнгэ аймаг дахь авто замын Алтанбулаг олон улсын хилийн боомт	85	14
Бүгд	191	22

Хүснэгт 2. Ганцаарчилсан ярилцлагад хамруулах төрийн байгууллага болон ХХЕГ-ын холбогдох мэргэжилтний тоо (n=54)

№	Ярилцлага хийх субъект	Ганцаарчилсан ярилцлагын тоо
1	Үйлчлүүлэгч иргэн	2

2	Үйлчлүүлэгч ААНБ	2
3	Боомтын холбогдох албан тушаалтан, төлөөлөл	4
4	ХХЕГ-ын газар нэгжийн, удирдлага	5
7	Нийт	13

Нэг. ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХУУЛЬД ЗААСАН НИЙТЛЭГ БОЛОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газраас Хилийн тухай хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, Хилийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан хил хамгаалалтын үндсэн зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон 2022 онд хүн (Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн), хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээнд хөндлөнгийн үнэлгээг хийхдээ нийтлэг болон тусгай чиг үүргийн хүрээнд зааглан судлан үзсэн болно.

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Үндсэн хууль, бусад хуулийг биелүүлэх зорилгоор тогтоол, захирамж гаргаж биелэлтийг хангах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч, эрх зүйн мэдээлэл, сургалт, хууль тогтоомж тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулах ажлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх ажлын хүрээнд улсын хил хамгааллын асуудал, хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа хийх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж буй байдлыг Хил хамгаалах байгууллагын нийтлэг чиг үүрэгт судалгааны багийн зүгээс тодорхойлон улсын хилийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн дунд эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах болон олон нийтэд чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгаа, соёлын үйлчилгээний чанар хүртээмж, иргэний шаардах эрхийн баталгаа түүний хэрэгжилтийг, харин тусгай чиг үүргийн хүрээнд хүн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээ хөндлөнгийн үнэлгээний бодит үр дүнг эрэлхийлэхийн тулд хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, боомтын аюулгүй байдлыг хангах ажиллагаа, хил хамгаалах байгууллагын алба хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа гэсэн 3 бүлэг агуулгын хүрээнд Хууль зүйн сайдын 2015 оны А/175 тушаалын хавсралтаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэн асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийг үндэслэн тус тус дүн шинжилгээ хийж ажилласан болно.

Хил хамгаалах ерөнхий газар нь Засгийн газрын тохируулагч агентлагийн хувьд Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2022 онд шинээр батлан хэрэгжиж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг дор дурдсанаар зохион байгуулан ажилласан байна.

1. Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Хилийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт, 8.4 дэх хэсгийг үндэслэн Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2022 оны А/205 дугаар тушаалаар баталсан “Ёс зүйн дүрэм”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг Хилийн цэргийн анги, тусгай салбарт ёс зүйн дүрмийн агуулгыг тайлбарлан таниулах видео танилцуулга бэлтгэн байгууллагын bro.gov.mn хуудсаар сурталчлах;

2. Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн шинэчилсэн найруулга батлагдан 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөнтэй холбогдуулан Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2022 оны А/55 дугаар тушаалаар Хил хамгаалах ерөнхий газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн, мөн 2022 оны А/166 дугаар тушаалаар “Хилийн цэргийн ангиудын харьяа, амралтын газруудад албан хаагчдыг амраах түр журам”-ыг боловсруулах;

3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх, хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Tridum-key” ХХК-аас тоон гарын үсгийн гэрчилгээ, төхөөрөмжийн хамт худалдан авч, “Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн сан”-гаас олгох лавлагаа-мэдээллийг тоон гарын үсгээр баталгаажуулан 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн хууль, хяналтын 7 байгууллагад төрийн цахим шуудан болон edoc программыг тус тус ашиглан илгээх, хүлээн авах цахим бичиг хэргийн эргэлтийг зохион байгуулж ажиллажээ. Хилийн тухай хууль, бусад хууль тогтоомжийг тайлбарлан таниулах зорилгоор видео шторк, подкаст бэлтгэн байгууллагын цахим хуудсаар олон нийтэд хүргэх;

4. Засгийн газрын 2017 оны 174 дүгээр тогтоол “Хилийн цэргийн алба хаагчийн дүрэмт хувцас болон хэрэглэлийн норм, эдэлгээний хугацаа, хүнсний хангамжийн хэмжээ, хилийн нэмэгдэл олгох журам батлах журам”-ын шинэчилсэн найруулгын төсөл, танилцуулгыг боловсруулж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

5. Хилийн цэргийн анги, тусгай салбарын захиргаа, хүний нөөц, сэтгэл зүйн хангалтын бие бүрэлдэхүүнд удирдлагын шийдвэрийг хүргэх, хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцох, баримт бичиг боловсруулах, архив, албан хэрэг хөтлөлт, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлангийн биелэлт гаргах аргачлал, ангийн захирагчийн тушаал гаргахад шаардлагатай эрх зүйн үндэслэлийг тодорхойлох талаар арга зүйн зөвлөгөө өгч, хилийн цэргийн анги, боомтын бүрэлдэхүүнд сахилгын, захиргааны, хүний эрхийн зөрчил, гэмт хэргийн тухай ойлголт, хүлээлгэх хариуцлага, үр дагавар зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг явуулж, авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах талаар эрх зүйн мэдээлэл, сургалт зохион байгуулж нийтлэг чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн Хил хамгаалах ерөнхий газрын Хууль, эрх зүйн хэлтсийн 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 19 арга хэмжээ төлөвлөснөөс 100 хувь бүрэн хэрэгжүүлж, нэмэлтээр 79 ажил хэрэгжүүлжээ.

1.1. ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ

1.1.1. Эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр олон нийтэд чиглэсэн ажил үйлчилгээ

Хилийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт ... соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон бусад нэгжтэй байна гэж заасны дагуу Хилийн цэргийн тусгай салбар Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулга, Улсын хилийн музей, эрдэм шинжилгээ, судалгааны бусад байгууллагатай хамтран эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх, хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах, мэдлэг ойлголтыг төлөвшүүлэхэд чиглэсэн дор дурдсан ажил, үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд үзүүлжээ.

Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын 2.1.12-т иргэдийн эх оронч үзэл, улсын хил, хилийн дэглэм, журмыг хүндэтгэн сахих хүмүүжлийг төлөвшүүлэх гэж заасан үндсэн чиглэлийн хүрээнд Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулга нь төлөвлөгөөт 111, төлөвлөгөөт бус 167 үүнээс бүрэн хэмжээний 33, хэсэгчилсэн 183, цөөхүүл 62 нийт 278 удаагийн тоглолт зохион байгуулж, нийт 108 удаагийн бүрэн хэмжээний болон хэсэгчилсэн тоглолт, 62 удаагийн үдэшлэгийг зохион байгуулж, 6000 орчим хилчид, хил орчмын нутаг дэвсгэрт байнга оршин сууж буй иргэдэд соёл урлагийн үйлчилгээ үзүүлжээ.

Улсын хилийн музей нь Хил хамгаалах байгууллага, хилчдийн байгуулсан гавьяа, түүх, хилчдийн үйл ажиллагааны талаар мэдээлэл, гэрэл зургийн үзэсгэлэнг сургуулийн өмнөх боловсролын байгууллага, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, их, дээд сургуулийн багш, оюутан, суралцагч, иргэд үзүүлж, байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан байна. Түүнчлэн Хил хамгаалах байгууллага нь дотоод хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын Боловсролын их сургуультай 2022-2025 онд хамтран ажиллах санамж бичиг солилцож, тус санамж бичгийн 3.5-д Оюутан, залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор өдөрлөг, уулзалтыг хамтран жил бүр хамтран зохион байгуулах, 3.6-д Эх орны үзэсгэлэнт байгаль, түүхэн газар орноор оюутан, залуучуудыг тойрон аялуулахад холбогдох хууль, дүрмийн хүрээнд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Баатарлаг хилчдийн жим”-ээр аяллыг Хилийн цэргийн 0101 дүгээр ангид 11 дүгээр сарын 25, 26-ны өдөр зохион байгуулж, уг аялалд сэтгэл судлалын 4 багш, сэтгэл судлалын төгсөх ангийн 25 оюутныг оролцуулсан байна.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Улсын хилийн музейгээс “Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн гэрээ-60 жил” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын үед Гадаад хэргийн яам болон Архивын ерөнхий газраас үзэсгэлэнд дэлгэх боломжтой гэрэл зургийг авч, бодит байдлыг харуулах, танилцуулах, цаашид музейн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор сурталчилжээ.

Оросын Холбооны Улсын Холбооны аюулгүй байдлын албаны Хилийн удирдах газрын урилгаар Хил хамгаалах ерөнхий газрын даргын баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Хилийн цэргийн тусгай салбар, Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулга 9 дүгээр сарын 19-24-ний өдөр Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Алтай Улсын Горный-Алтай хотод “Энхийн хилчид” бүрэн хэмжээний хамтарсан тоглолтыг зохион байгуулж, мөн Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Оросын Холбооны Улсын хилийн бүрэн эрх төлөөлөгчдөд зориулсан уулзалтад 20 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг Хил хамгаалах байгууллага, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулгын үйл ажиллагааг соёл урлагаар дамжуулан сурталчилжээ. Түүнчлэн иргэдийн эх оронч үзэл, улсын хил, хилийн

дэглэм, журмыг хүндэтгэн сахих хүмүүжлийг төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор МҮОНТВ-тэй хамтран “Дархан хилийн цадиг” нэвтрүүлэг, “Хязгаарын салаа” теле концертыг бэлтгэн 3 дугаар сарын 16, 18-ны өдөр ТВ8, TV5, SBN, Малчин телевизийн эфирээр иргэд, олон нийтийн хүртээл болгон Хил хамгаалах байгууллага, хилийн түүхийн мэдлэг, мэдээлэл олж авах, хүртээмжтэй, сэтгэл ханамжтай үйлчилгээг чанартай хүргэхэд анхаарч ажиллажээ.

“Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын 2.2.2-т хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны үндэс болгох гэж заасан үндсэн чиглэлийн хүрээнд холбогдох яам, агентлаг, эрдэм шинжилгээ, судалгааны бусад байгууллагатай хамтран эрдэм шинжилгээний хурал 6-г зохион байгуулснаас Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гадаад харилцааны яамтай хамтран “Монгол Улс, БНХАУ-ын хилийн гэрээ-60 жил” олон улсын эрдэм шинжилгээний хурал 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Гадаад харилцааны яамны “Зөвшилцөл” танхимд зохион байгуулсан. Монгол, Хятадын хилийн нийт урт 4709.6 километр бөгөөд уг хилийн хэсгийг хоёр улсын Засгийн газрын төлөөлөгчдийн хамтарсан бүлэг 1962 онд хилийн гэрээг байгуулан газар дээр нь тогтоон тэмдэглэж, 1975 онд НҮБ-д албан ёсоор бүртгүүлсэн байдаг. Үүнээс хойш хоёр улсын хилийг 1982-1984 онд анх удаа, 2001-2004 онд хоёр дахь удаагаа хамтран шалгаж, баталгаажуулсан үйл явдлыг өнөөдөр дахин сөхөж, түүхэн үүргийг эрдэмтэн судлаачид тодотгон тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын илэрхийлэл болсон улсын хилийн шугамыг хөрш зэргэлдээ оронтойгоо баталгаажуулаад зогсохгүй дэлхий нийтэд хүлээн зөвшөөрүүлж чадсан түүхэн ач холбогдлыг өгүүлсэн эрдэм шинжилгээний хурал гэж үнэлжээ.

Мөн ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимээс “Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хилийн боомтын чадавхийг нэмэгдүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 3 дугаар сарын 22-ны өдөр, ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгээс анх удаа ХХЕГ, Хилийн цэргийн хил судлалын хүрээлэн, хилийн цэргийн ... дүгээр ангитай хамтран “Хил орчмын аялал жуулчлалын бүсэд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах онцлог, асуудал, шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион тус тус зохион байгуулж, Хил хамгаалах байгууллага хамтын ажиллагаа, үйлчилгээний төрөл, хэлбэр, хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн бүс, зурвас дахь аж ахуй нэгжийн үйл ажиллагаа хилийн аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад хамтран ажиллах арга хэлбэрийг тодорхойлоход чиглэсэн дүгнэлт, саналыг хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны үндэс болгон хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлснээр иргэдийн эх оронч үзлийг хийсвэрлэхгүйгээр сургалт, судалгааны үр дүнтэй аргаар төлөвшүүлэхэд чиглэсэн ажил болжээ.

1.1.2. Мэдээллийн ил тод байдал, хүртээмж

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь хэсэгт зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвч, төрийн цэргийн байгууллагын нэгтгэл, ангийн байлдааны цагийн орон тоо, жинхэнэ нэр, зохион байгуулалт, бүтэц, тэдгээрийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт, мэдээлэл, төрийн цэргийн байгууллагын стратегийн удирдамж, бэлэн байдлын төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, тооцоо, зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, хэрэглэх болон стратегийн төлөвлөлтийн баримт бичиг, батлан хамгаалах болон улсын хил хамгаалах зориулалттай болон хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан байр зүйн зураг, төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо

бүртгэл, бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээлэл, цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо, төрийн цэргийн байгууллагын удирдлагын байрны байршил, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны арга ажиллагаа, хангалтыг зохион байгуулахтай холбоотой мэдээлэл, улсын болон батлан хамгаалах нөөцийн бодит хэмжээ, байршил, тайлан, санхүүжилтийн тухай мэдээлэл зэрэг ХХЕГ-т хамаарах олон мэдээллийг төрийн нууцад хамааруулахаар заажээ. Харин Нийтийн мэдээллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх заалтуудад танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж, хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг хаалттай мэдээлэл гэж тус тус үзэхээр заасан байна. Хуульд заасан эдгээр үндэслэлээр ХХЕГ-ын үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүд ихэвчлэн хаалттай эсвэл хязгаарлалттай мэдээлэл байдаг байна.


Гэвч Нийтийн мэдээллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.7 дахь заалтуудад хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй бөгөөд нийтийн мэдээллийг ашиглахад хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, хүн, хуулийн этгээд хуулиар хязгаарлалт тогтоогоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлнэ гэж заасны дагуу ХХЕГ-ын үйл ажиллагаатай холбоотой зарим мэдээлэл нээлттэй байх нь зайлшгүй юм.

Цаашид ХХЕГ-аас тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой чухам ямар мэдээлэл нь ямар үндэслэлээр төрийн болон албаны аливаа нууцад хамаарч хязгаарлалттай эсвэл хаалттай мэдээллийн алинд нь хамаарч байгаа тухай мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх нь зүйтэй гэж үзэж байна.

ХХЕГ нь Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрийн 4.1.5 дахь зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, үйлчилгээний шат дамжлагыг багасгах, чанар, хүртээмжийг нь нэмэгдүүлэх зорилгоор Хил хамгаалах байгууллагаас үзүүлдэг үйлчилгээний хүсэлтийг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, архивын үйлчилгээний хүсэлт хүлээн авах программыг 2020 оноос үйл ажиллагаандаа ашиглаж, “Хилийн цэргийн төв архивын үйлчилгээ” хэсэгт холбогдох линкийг байршуулсан бөгөөд www.archive.bpo.gov.mn хаягаар нэвтэрч үйлчилгээ авах боломжтой болжээ.

Зураг 1. Хилийн цэргийн тусгай архивын онлайн захиалгын хуудас

archive.bpo.gov.mn

**ХИЛИЙН ЦЭРГИЙН ТУСГАЙ АРХИВ
ОНЛАЙН ЗАХИАЛГА**

Та Хилийн цэргийн тусгай архивт хадгалагдаж буй баримтаас лавлагаа, тодорхойлолт захиалах боломжтой. Үүнд:

- Хил хамгаалах байгууллагад 1990 оноос хойш ажилласан тухай лавлагаа;
- Хилийн анги, тусгай салбарт 1980-2006 онд ажиллаж байсан үеийн цалингийн тодорхойлолт;
- Хилийн цэргийн ангиудад 1990 оноос хойш хугацаат цэргийн алба хаасан тухай лавлагаа;
- 1990 оноос хойшхи баримтын хуулбар.

Та архивын лавлагаа, тодорхойлолт авахдаа "Архивын тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30.4-д заасны дагуу үйлчилгээний хөлс төлнө. Үйлчилгээний төлбөрийг Төрийн сан 100900012016 тоот дансанд шилжүүлнэ. Лавлагааны хариуг ХЦ-ийн тусгай архиваас биеэр ирж авах бөгөөд онлайнаар өгөх боломжгүй.

Лавлагаа гарсан тохиолдолд Танд утсаар мэдэгдэнэ.
Холбогдох утас: (51) 266628


* Регистрийн дугаар

Регистрийн дугаараа оруулна уу!

* Лавлагаа


Мөн Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д 2021 оны 12 дугаар сард холбогдон өмнө дурдсан Хилийн цэргийн төв архиваас олгох ажилласан хугацааны, цэргийн алба хаасны, цалингийн лавлагаа, тодорхойлолт, баримтын хуулбар зэрэг 4 төрлийн үйлчилгээний хүсэлтийг болон бусад 49 үйлчилгээ буюу нийт 53 үйлчилгээг Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аас авах боломжтой болсон байна.


Зураг 2. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аас авах боломжтой Хил хамгаалах ерөнхий газрын үйлчилгээнүүд


Нүүр ҮйлчилгээнүүдАТГ-т өргөдөл гомдол гаргахCovid-19

ИргэнАж ахуйн нэгж байгууллагаГадаадын иргэн


Үйлчилгээний горим: ПорталҮйлчилгээний төрөл: Байгуулл...Төлбөртэй эсэх: Бүгд

 Бүх үйлчилгээ 1630

 Замын-Үүд Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба 3

 Алтанбулаг Чөлөөт бүсийн ажлын алба 1

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГА

 Хил хамгаалах ерөнхий газар 53

Хилийн цэргийн төв архивын мэдээлэл, үйлчилгээ

Архивын үйл ажиллагааны хүрээнд Хил хамгаалах байгууллагын 2022 онд дэвшүүлсэн зорилт, Хил хамгаалах ерөнхий газрын даргын “Монгол Улсын хил хамгаалалтыг 2022 онд зохион байгуулж, удирдах тухай удирдамж”, Захиргааны удирдлага эрхэлсэн дэд даргын 2021 оны 08 дугаар захирамжийг хэрэгжүүлж, тухайн онд 2250 байгууллага, иргэний хүсэлтийг хүлээн авч 2871 лавлагаа, тодорхойлолт, хуулбар гаргаж архивын мэдээллээр үйлчилсэн байна.

Хилийн цэргийн төв архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх төлөвлөгөөний дагуу Цэргийн албаны хэлтсээс 25, Хилийн тагнуулын газраас 30, Хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албанаас зураг төслийн баримт 25, Зэвсэг, химийн албанаас 87, нийт 167 баримт хүлээн авсан. Мөн архивын баримтаас 2022 онд 7 хөмрөгийн 98 хадгаламжийн нэгжийн 24,500 хуудас баримтыг цахимжуулж, photoshop программыг ашиглан бичвэр тодруулах, сэв, толбо арилгах ажилбар хийж, архивын цахим санд холбосон байна.

Хэвлэл мэдээлэл болон цахим орчин

ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагуудын 2022 онд хэвлэл мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөний биелэлтийн хангах хүрээнд “Хил хамгаалах байгууллагын нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журам”-ыг баталжээ.

Хил хамгаалах байгууллага, хилчдийн алба үйл ажиллагааг “Хил хамгаалах байгууллага” цахим хуудас, 5 телевиз (МҮОНТ, Боловсрол, ТВ-2, ТВ-8, Малчин), өдөр тутмын 6 сонин (Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ, Өглөөний сонин, Монголын мэдээ, Үндэсний шуудан), 6 сайт /Монголын сайтуудын нэгдсэн холбоо, Зиндаа.мн, Улстөрч.мн, Чек медиа, Черри медиа, LiveTV.mn/-тай хамтран ажиллаж, хилчдийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд эх сурвалжтайгаар мэдээлэх, цэргийн албаны талаар эерэг мэдээ мэдээллийг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан.










Цахим хэлбэрээр мэдээлэл хүргэх асуудлаар Монгол Улсын Хилийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хууль, бусад хууль тогтоомж, дүрэм журмаар видео шторк хийж цахим хуудсаар сурталчлах, Хилийн цэргийн төв архивын “E-Mongolia” хур системд нэвтрүүлсэн үйлчилгээний талаар иргэд ямар мэдээлэл лавлагааг авч болох талаар “Албаны тодруулга” буланд видео контент бэлтгэж, “Хил хамгаалах байгууллага” цахим хуудсаар олон нийтэд хүргэх ажлыг гүйцэтгэжээ.

Зураг 3. ХХЕГ-ын албан ёсны вебсайтад 2022 онд байрлуулсан видео контентууд

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ


МЭДЭЭ АНГИЛАЛ

- ▶ Цэг үе
- ▶ Дүрсгүй мэдээ

 <p>ЭРҮҮГИЙН ТУХАЙ ХУУЛЬ АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫ...</p> <p>2022.11.25 223</p>	 <p>ХИЛИЙН 0208 ДУГААР ТУСГАЙ САЛБАР, "ХИЛЧИН" СПОРТ ХОРООНЫ ТАМИРЧИН...</p> <p>2022.08.08 1595</p>	 <p>МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХОЕРДУГААР БҮЛЭГ 17 ДУГААР ЗҮЙЛҮ...</p> <p>2022.06.24 1591</p>
 <p>"ХИЛЧИД ЭНХИЙН ҮЙЛСЭД 20 ЖИЛ" БАРИМТАТ КИНО</p> <p>2022.05.27 2665</p>	 <p>"МОНГОЛ-ЭХ ОРОН" НАЙРАЛ ДУУ БОЛОН ГОЦЛОЛ ДУУНЫ УЛСЫН УРАЛДААН БО...</p> <p>2022.04.18 1958</p>	 <p>"СҮЛДЭТ БАГАНЫН ДЭРГЭДЭЭС" НЭВТРҮҮЛГИЙН ЭНЭ УДААГИЙН ДУГААРТ ЭГЭЛ...</p> <p>2022.04.05 1996</p>
 <p>МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО</p>	 <p>ХИЛИЙН 0306 ДУГААР АНГИЙН АЛБА ХААГЧИД ТОХИЛОГ ОРОН СУУЦТАЙ БОЛСН...</p>	 <p>ХИЛИЙН 0108 ДУГААР АНГИЙН АХЛАХ АХЛАГЧ Т.РЭНЦЭНБАДАМЫН 1100 КМ ХО...</p>

Хил хамгаалах байгууллагын цахим хуудаст 586 мэдээ, мэдээлэл, 120 видео контент бэлтгэн нийтэлж, 3 шторк хийсэн бөгөөд “Хил хамгаалах байгууллага” фэйсбүүк хуудасны дагагчийн тоо 80,466 хүрч 2022 онд 12,466-аар нэмэгдэн, 57,855 лайк хандалт авсан нь өмнөх жилийнхээс 6,510-аар өссөн байна. Харин цахим мэдээллийг 1,892,102 хүн уншсан нь өмнөх жилээс 21 хувиар өссөн бөгөөд 43,116 хүн шинээр зочилж, мэдээ, мэдээлэл авсан үзүүлэлттэй байна.

Зураг 4. “Хил хамгаалах байгууллага” фэйсбүүк хуудас



“Эх орны манаа” сонины 36, тусгай 1 дугаарыг эрхлэн гаргаж, нийт 500 гаруй мэдээ, 220 гаруй ярилцлага, 150 гаруй нийтлэл, сурвалжилга бэлтгэж сэтгүүл зүйн бичлэгийн бусад төрөл зүйлээр материал бэлтгэн нийтлүүлж, хилчдэд хүргэсэн. Түүнчлэн сонины цахим хуудсыг шинээр нээж, 8,000 гаруй дагагчтай болсон. Нийт хилчдэд “Эх орны манаа” сониныг цахимаар унших нөхцөлийн бүрдүүлж, удирдлагын таб төхөөрөмж, E-Office програмд сонины шинэ дугаар бүрийг шилжүүлэн, мэдээ мэдээллийг хүргэсэн байна.

“Хилчин” студийн үйл ажиллагааны талаар:

“Сүлдэт баганын дэргэдээс” нэвтрүүлгийн 12 дугаар, “Хилчдийн өдөр”-т зориулсан 1 тусгай дугаар, нийт 13 дугаарыг давхардсан тоогоор хилийн 10 анги /0214, 0287, 0131-2, 0166-2, 0243, 0101, 0132, 0306/-аас бэлтгэн, харилцан ажиллагаатай МҮОНТ, Малчин, ТВ-8, ТВ-2, Боловсрол телевизийн эфирээр олон нийтэд хүргэсэн.

Хилийн цэргийн 0166 дугаар ангийн хилчид говийн их дархан дархан цаазат төрийн тусгай хамгаалалтын газар, онгон дагшин байгаль, нэн ховор ан амьтдыг хэрхэн хайрлан хамгаалж байгаа, говь цөлийн бүсийн байгаль цаг уурын онцлог, хүндрэл бэрхшээлийн талаар танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн сурталчилсан.

Хил хамгаалах байгууллага, хилчдийн албаны үйл ажиллагааг сурталчилж, иргэд, олон нийтийг бодит мэдээ, мэдээллээр шуурхай хангах үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Түүнчлэн Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2022 оны “Ёс зүйн дүрэм батлах тухай” А/205 дугаар тушаалыг сурталчлах зорилгоор Хилийн цэргийн анги, тусгай салбарын “Ёс зүйн салбар зөвлөл”-үүд өгөгдсөн сэдвийн хүрээнд ёс зүйн дүрмийн агуулгыг тайлбарласан видео танилцуулга бэлтгэн байгууллагын цахим хуудсаар сурталчилсан байна.

Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлын үнэлгээ

Төрийн үйлчилгээний E-Mongolia бүртгэлийн системээр ХХЕГ-т 188 хүсэлт ирүүлснийг шийдвэрлэж, цахим хаягаар 576 мэйл хүлээн авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн бөгөөд байгууллагын цахим хаягаас 360 мэйл илгээсэн байна.

Энэхүү судалгааны үр дүнгээс үзвэл Хил хамгаалах байгууллагаар үйлчлүүлэгчдийн 21.5 хувь буюу 5 хүн тутмын 1 нь нийгмийн сүлжээнээс, 16.9 хувь нь найз нөхөд, хамаатан садан болон бусад, 15.5 хувь нь телевизээс мэдээлэл авдаг байна. Түүнчлэн үйлчлүүлэгчдийн 8.6 хувь нь Хил хамгаалах ерөнхий газрын цахим хуудас, 9.1 хувь нь хил хамгаалах байгууллагаас мэдээлэл авсан гэж хариулсан байна. Иймд цахим хэлбэрээр мэдээлэл авч буй байдал харьцангуй өндөр бөгөөд тус хэлбэрээр ХХЕГ болон хилийн боомтын талаарх мэдээллийг хүргэвэл үр дүн гарахаар байна.

График 1. Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ) болон хилийн боомтын талаарх мэдээллийг голлон авч буй мэдээллийн суваг




Харин үйлчлүүлэгчид ХХЕГ болон хилийн боомтын талаар дараах төрлийн мэдээллийг түлхүү авах сонирхолтой байна. Үүнд:

1. чиг үүрэг оролцоо
2. ахмад хилчдийн намтар мэдээлэл
3. гадаадаас илгээмж авах талаар зөвлөгөө зөвлөмж
4. үйлчилгээний төрөл
5. хил гааль, хил нэвтрэх тухай
6. хил хамгаалах байгууллагын шинэчлэл
7. хилийн ажиллах хуваарь, баярын үеэр эсхүл онцгой үед
8. хилийн боомтын үйл ажиллагаа
9. хилийн бүсэд мөрдөх журам
10. хилийн зурвасаар нэвтрэх
11. хилийн шалганд шаардагдах мэдээлэл материал
12. хилчин залуучуудын тухай
13. хилээр нэвтрэх эрх зүйн баримт бичиг

14. чөлөөт бүсээр нэвтрэх, гарах дүрэм журмыг хурдан шуурхай, цахим хэлбэрээр авах хүсэлтэй болохоо илэрхийлжээ.

Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 39.9 хувь нь ХХЕГ ба хилийн боомтын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, нээлттэй, ил тод байдаг гэж үзсэн бол 32 хувь нь санал нийлэхгүй байна. Эндээс үзвэл иргэд, үйлчлүүлэгчдийн зүгээс ХХЕГ ба хилийн боомтын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээллийг төдийлөн хүртээмжтэй авч чаддаггүй байна. Мөн судалгаанд хамрагдсан иргэдийн хариултыг үйлчлүүлсэн хилийн боомтоор харьцуулан авч үзвэл Алтанбулаг боомтоос судалгаанд хамрагдсан иргэдийн 58.9 хувь нь нээлттэй, ил тод гэж үзсэн байхад Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй иргэдийн хувьд 34.1 хувиар бага буюу 24.8 нь хувь нээлттэй, ил тод гэж үзсэн байна. Хилийн боомтоос хамаарч үйлчлүүлж буй иргэд харилцан адилгүй үнэлгээ өгч, ялгаатай ойлголт мэдлэгтэй байгааг цаашид анхаарч мэдээллийн хүртээмжийг жигд сайжруулах шаардлагатай байна.

График 2. ХХЕГ ба хилийн боомтын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, нээлттэй, ил тод эсэх



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 27.3 хувь буюу 4 хүн тутмын 1 нь Хил хамгаалах ерөнхий газрын цахим хуудаст зочилж байсан туршлагатай байна. Түүнчлэн байршлаар авч үзвэл төдийлөн ялгаа ажиглагдахгүй буйг доорх график 3-аас харж болно. Хил хамгаалах ерөнхий газрын цахим хуудаст зочилж байсан үйлчлүүлэгчдийн 29.7 хувь нь л хэрэгтэй мэдээллээ авч чадсан байгаа нь хангалтгүй үзүүлэлт гэж үзэж байна.

График 3. Хил хамгаалах ерөнхий газрын цахим хуудаст зочилж байсан байдал





График 4. Хил хамгаалах ерөнхий газрын цахим хуудаст зочилж хэрэгтэй мэдээллээ авч чадсан эсэх



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 19.5 хувь Хил хамгаалах ерөнхий газартай утсаар холбогдсон туршлагатай байна. Түүнчлэн байршлаар авч үзвэл Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй иргэдийн 21.9 хувь буюу Алтанбулаг боомтоор үйлчлүүлэгчдээс 4.2 хувиар илүү утсаар холбогдсон байна. Мөн Хил хамгаалах ерөнхий газартай утсаар холбогдож байсан үйлчлүүлэгчдийн 26.4 хувь нь буюу ойролцоогоор 4 хүн тутмын нэг нь л хэрэгтэй мэдээллээ авч байгаа нь ерөнхийдөө хангалтгүй үзүүлэлт байна.

График 5. Хил хамгаалах ерөнхий газартай утсаар холбогдсон байдал






График 6. Хил хамгаалах ерөнхий газартай утсаар холбогдож хэрэгтэй мэдээллээ авч чадсан эсэх



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн зүгээс утсаар мэдээлэл өгөх байдлыг муу гэж үнэлсэн байдал хамгийн өндөр буюу 7.5 хувь байгаа бол мэдээллийн самбараар мэдээлэл өгөх байдлыг 4.9 хувь нь муу гэж үнэлсэн нь хамгийн бага хувьтай байна. Үйлчлүүлэгчдийн 93.8 хувь нь мэдээлэл өгч буй байдлыг дунд, сайн, маш сайн гэж үнэлсэн байна.

График 7. Үйлчлүүлэгчид мэдээлэл өгч буй хэлбэрийг үнэлсэн байдал



Хил хамгаалах байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах хүрээнд мэдээллийн ил тод, байдалтай холбогдох дараах саналыг үйлчлүүлэгчдийн зүгээс дэвшүүлжээ. Үүнд:

- иргэдэд мэдээлэл өгөх;
- мэдээллийн ил тод байдлыг дээшлүүлэх;
- цахим мэдээлэл илүү сайжруулах.

Байгууллагын үйл ажиллагааны онцлог, хууль тогтоомжийн зохицуулалтаас шалтгаалан ХХЕГ-ын зарим мэдээлэл хаалттай болон хязгаарлалттай байдаг боловч тус байгууллага 2022 онд цахим хэлбэрээр мэдээлэл, үйлчилгээг хүргэхэд анхаарч ажилласан нь иргэд, байгууллагын хэрэгцээнд нийцсэн сайшаалтай үйл ажиллагаа байжээ. Ялангуяа байгууллагын веб хуудсаар болон Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аар дамжуулан үйлчилгээ үзүүлж, цахим контент бэлтгэх, фэйсбүүк хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн байна. Судалгааны багийн зүгээс ХХЕГ нь мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхдээ цаашид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналтай байна. Үүнд:

- байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нь ямар үндэслэлээр төрийн болон албаны аливаа нууцад хамаарч хязгаарлалттай эсвэл хаалттай мэдээллийн аль нь болох тухай мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэж тайлбарлах;
- ХХЕГ-ын чиг үүрэг, түүх, хилийн боомтын бодлого, хил нэвтрэх тухай заавар зэрэг мэдээллийг нийгмийн сүлжээ, телевизийн сувгаар голчлон дамжуулах;
- Хилийн боомтоос хамаарч үйлчлүүлж буй иргэд харилцан адилгүй үнэлгээ өгч, ялгаатай ойлголт мэдлэгтэй байгааг цаашид анхаарч мэдээллийн хүртээмжийг жигд сайжруулах;
- утсаар болон вебсайтаар хүргэх мэдээллийн агуулгад анхаарч үйлчлүүлэгчдийн хүсэж байгаа мэдээллийг хүргэх.

1.1.3. Иргэний шаардах эрхийн баталгаа: өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байдал

Төрийн байгууллагад өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх нь иргэдийн үндсэн эрх, иргэд засаглалд оролцох оролцооны уламжлалт хэлбэр юм. Нийгмийн амьдралд идэвхтэй оролцон, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, алдаа дутагдал, зөрчил гажуудлыг нь арилгах хэлбэрээр өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх иргэний эрх хэрэгждэг. Энэхүү эрхийг хуулиар хамгаалан баталгаажуулах нь иргэд өөртөө болон нийгмийн бүлэг, нэгж, нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх, шийдвэр гаргахаас өмнө олон талт хүчин зүйлийг судлах боломж бүрдүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг залруулах, алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх, хууль ёсны зарчмыг сахиулахад чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэж заасан. Мөн 1995 онд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг баталсан нь өргөдөл гомдол гаргагчийн эрх, түүнийг хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн.

Хил хамгаалах байгууллагад хандаж иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2016 оны А/167, 2019 А/38 дугаар тушаалыг удирдлага болгон Хил хамгаалах байгууллагын удирдлагад хандаж иргэд, алба хаагчдаас гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бичгээр болон нээлттэй утас /51260994/, байгууллагын цахим хуудасны /www.bpo.gov.mn/ өргөдөл, гомдол гаргах булан, Засгийн газрын “11-11” төвөөр дамжуулан хүлээн авч, өргөдөл гомдол, санал хүсэлтийг “Letter” программд бүртгэж, шийдвэрлэлтийг тусган ажилладаг байна.


Дээрх үйл ажиллагааг хэрэглэгчид хэрхэн үнэлж байгааг иргэд, албан хаагчидтай ярилцлага хийх, Хил хамгаалах ерөнхий газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн бүртгэл, тайлан, холбогдох мэдээллийг судлах байдлаар үнэллээ. Үүнд:

- Хил хамгаалах байгууллагын хэмжээнд 2022 оны 1 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл нийт 2219 өргөдөл, гомдол ирснээс 2171 өргөдөл, гомдлыг байгууллагын эрх хэмжээнд шийдвэрлэн зохих хариуг өгч, 48 өргөдөл, гомдлыг судалж байна. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол Засгийн газрын “11-11” төвд 27 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 97,7 хувьтай байна.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын гишүүд, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шийдвэрлүүлэхээр уламжлан ирүүлсэн 14 өргөдлийн хариуг өгч, 2 өргөдөл судлагдаж байна.
- Өргөдөл, гомдол хянан хэлэлцэж дүгнэлт гаргах комиссын 10 удаагийн хуралдааныг зохион байгуулж, эмчилгээний зардалд тусламж, дэмжлэг үзүүлэхийг хүссэн 23, орон сууцны дэмжлэг үзүүлэх, гэр олгохыг хүссэн 4, цэргийн алба хаагчийн нэг удаагийн тэтгэмжийн 18 сар хүртэлх хугацаанд ногдох хэсгийг урьдчилан олгохыг хүссэн 12, бусад асуудлаар 2 нийт 41 хүний өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.
- Хил хамгаалах ерөнхий газрын хэмжээнд ирсэн Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2022 оны 1-11 сарын тайланг байгууллагын цахим хуудаст байрлуулсан.

1.1.4. Үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжид үйлчлүүлэгчдийн өгсөн үнэлгээ


ХХЕГ-ын хэрэглэгчийн үнэлгээний судалгааны хүрээнд хэрэглэгч, үйлчлүүлэгчээс анкетын асуулгаар мэдээлэл цуглуулах ажлыг 2022 оны 12 сарын 19-ний өдрөөс 12 сарын 24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Судалгааны хүрээнд нийт 213 анкет цуглуулсныг нэгтгэн үр дүнг боловсруулсан болно. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг ХХЕГ-ын чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулж буй 2 байршилд хийв.

График 8. Судалгаанд оролцогчдын байршил



Судалгаанд оролцогчдын 54 хувь буюу 114 нь Хөшигийн хөндийн нисэх буудлаас, 46 хувь буюу 114 нь Алтанбулаг боомтоос үйлчилгээ авсан байна.

График 9. Судалгаанд оролцогчдын нас, хүйс




Судалгаанд оролцогчдын 70.2 хувь нь 40 хүртэлх насныхан байна. Алтанбулаг боомтоос судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 24.3 хувь нь, Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлаас хамрагдсан үйлчлүүлэгчдийн 39.6 хувь нь 18-30 настай байна. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа тэнцвэртэй буюу 46.6 хувь нь эрэгтэй, 53.4 хувь нь эмэгтэй байна.

График 10. Судалгаанд оролцогчдын боловсрол, ажил эрхлэлт




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 31.3 хувь нь техник болон мэргэжлийн дунд боловсролтой байна. Алтанбулаг боомтоос оролцогчдын дийлэнх буюу 23.2 хувь нь бага боловсролтой байгаа бол Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлаас хамрагдсан үйлчлүүлэгчдийн 40.7 хувь нь техник болон мэргэжлийн дунд боловсролтой байна. Ажил эрхлэлтийн хувьд Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлаас судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 47.4 хувь ажилгүй байгаа нь хамгийн өндөр хувьтай байна. Харин Алтанбулаг боомтоос үйлчлүүлэгчдийн 47.4 хувь нь хувийн компанид ажиллагсад байна.

График 11. Судалгаанд оролцогчдын авсан үйлчилгээний төрөл болон иргэн болон ААНБ-ын төлөөллийн харьцаа




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 50.6 хувь нь хилийн зурваст нэвтрэх тусгай зөвшөөрөл авсан бол 35.5 хувь нь хилийн бүсэд нэвтрэх тусгай зөвшөөрөл авсан байна. Мөн судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдийн 14 хувь нь ХХБ-аас ямар төрлийн үйлчилгээ авснаа хэлж мэдэхгүй байна. Судалгаанд оролцогчдын 88.8 хувь нь иргэн байгаа бол 11.2 хувь нь ААНБ-ын төлөөлөл байна.

График 12. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд ХХБ-аар үйлчлүүлсэн эсэх




Судалгаанд оролцогчдын 56.5 хувь нь сүүлийн 1 жилийн хугацаанд ХХБ-аар 1 удаа үйлчлүүлсэн бол 43.5 хувь нь 2 болон түүнээс дээш удаа үйлчлүүлсэн байна.

График 13. ХХЕГ-аас үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээл гарсан эсэх, Хилийн зурваст үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад ХХБ-аас шалтгаалсан хүндрэл бэрхшээл тохиолдсон эсэх



Судалгаанд оролцогчдын 10.1 хувь нь ХХЕГ-аас үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээл гарсан гэсэн бол 11.4 хувь нь хилийн зурваст үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад ХХБ-аас шалтгаалсан хүндрэл бэрхшээл тохиолдсон гэжээ. Мөн байршлаас хамаарсан ялгаа төдийлөн ажиглагдахгүй байна.


График 14. ХХБ-ын алба хаагчийн ёс зүй, ур чадварт өгч буй үнэлгээ



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчид ХХБ-ын алба хаагчийн ёс, ур чадварыг өндрөөр үнэлж байна. Тухайлбал биеэ авч яваа байдал, мэргэжлийн ур чадварыг 98.1 хувь нь, боловсрол мэдлэгийг 97.1 хувь нь, шударга байдал, хариуцлагатай байдлыг 96.2 хувь нь, тэгш хандаж үйлчлэх байдлыг 95.7 хувь нь дунд, сайн, маш сайн гэж үнэлсэн байна.


ХХБ-ын алба хаагчийн ёс зүй, ур чадварт өгч буй үнэлгээ нь дээрх 6 үзүүлэлтийн дунджаар 96.9 хувьтай байна.

График 15. ХХЕГ-аас үйлчилгээ авахад зарцуулж буй хугацаа




ХХЕГ-аас үйлчилгээ авахад 1-2 өдөр зарцуулагдсан гэж судалгаанд оролцогчдын 57.7 хувь нь хариулсан байна. Мөн 35.3 хувь нь 3-7 өдөр зарцуулагддаг гэжээ. Мөн байршлаас хамаарсан ялгаа ажиглагдахгүй байна.

График 16. ХХБ-ын үйлчилгээний шат дамжлага, түргэн шуурхай байдалд өгч буй үнэлгээ




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчид ХХБ-ын үйлчилгээний чирэгдэлгүй, түргэн шуурхай байдлыг өндрөөр үнэлж байна. Тухайлбал үйлчилгээг тогтсон хугацаанд үзүүлэх байдал, үйлчилгээний цаг хугацаа алдахгүй шуурхай байдлыг 96.6 хувь нь, хүссэн үйлчилгээг авах шат дамжлага хялбар байдлыг 96.2 хувь нь, үйлчилгээ авах дараалал, чирэгдэлгүй байдлыг 95.2 хувь нь, иргэдийн бүрдүүлэх материалын уялдаа холбоог 95.1 хувь нь, нэг хүн дээр дахин дахин очиж чирэгдэл үүсгэхгүй байдлыг 93.7 хувь нь дунд, сайн, маш сайн гэж үнэлсэн байна. ХХБ-ын үйлчилгээний шат дамжлага, түргэн шуурхай байдалд өгч буй үнэлгээ нь дээрх 6 үзүүлэлтийн дунджаар 95.6 хувь байна.

График 17. ХХБ-ын үйлчилгээний хүртээмжтэй, ойлгомжтой байдалд өгч буй үнэлгээ



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчид ХХБ-ын үйлчилгээний хүртээмжтэй, ойлгомжтой байдлыг өндрөөр үнэлж байна. Тухайлбал доторх зохион байгуулалт, дотоод хаягжилтыг 96.1 хувь нь, байгууллагын хаягжилтыг 95.7 хувь нь, албан хаагчийн нэр, албан тушаал, үйлчилгээ үзүүлж буй орчин нөхцөлийг 95.6 хувь нь, үйлчилгээ үзүүлж буй тоног төхөөрөмж, үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарийг 95.1 хувь нь, ажилтнуудын тоо, хүрэлцээг 94.6 хувь нь дунд, сайн, маш сайн гэж үнэлсэн байна. ХХБ-ын үйлчилгээний хүртээмжтэй, ойлгомжтой байдалд өгч буй үнэлгээ нь дээрх 7 үзүүлэлтийн дунджаар 95.4 хувь байна.

График 18. ХХБ-ын үйлчилгээ илүү сайжирч байгаа гэдэгтэй санал нийлж буй эсэх



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 75.5 хувь нь ХХБ-ын үйлчилгээ илүү сайжирч байгаа гэж дүгнэжээ. Байршлаар авч үзвэл Алтанбулаг боомтоор үйлчлүүлэгчдийн 21.4 хувь нь хэвэндээ гэж үзсэн бол Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлаас судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 11.8 хувь нь үнэлж мэдэхгүй байна.

ХХБ-ын үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжийг сайжруулах хүрээнд дараах саналыг үйлчлүүлэгчдийн зүгээс дэвшүүлж байна. Үүнд:

- сургалт ойр ойрхон зохион байгуулах
- харилцаа хандлага дээр анхаарах
- хөнгөн түргэн шуурхай
- албан хаагчдын ажлыг хялбаршуулж тоног төхөөрөмж шинэчлэх шаардлагатай зэрэг саналыг илэрхийлсэн байна.

1.2. ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТУСГАЙ ЧИГ ҮҮРЭГ


1.2.1. Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ

Хилийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх зорилгоор хилийн боомтод улсын хил хамгаалах, гаалийн байгууллага, виз бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор гадаадын иргэн, харьяатын байгууллага ажиллана” гэж заасны дагуу хил хамгаалах байгууллага улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Авто замын Алтанбулаг, агаарын замын Чингис хаан боомтыг судалгааны түүвэрт хамруулан үйлчлүүлэгч (иргэн, хуулийн этгээд), хил хамгаалах байгууллагын алба хаагчаас асуулга болон ярилцлагын аргаар судалгаа авч хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд зохих үнэлгээ өгч ажилласан болно.

Хилийн хяналтын байгууллага улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхдээ улсын хилээр гарах хөдөлгөөний чиглэлд гаалийн, улсын хил хамгаалах байгууллага, улсын хилээр орох хөдөлгөөний чиглэлд улсын хил хамгаалах, гаалийн байгууллага гэсэн дарааллыг баримталж хяналт шалгалт явуулдаг байна.

Зураг 5. Хөшигийн хөндий нисэх буудал дахь хилийн шалган нэвтрүүлэх хэсэг 2022.12.19



Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн талаарх мэдээлэл, лавлагаа хүссэн төрийн эрх бүхий байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, албан хүсэлт /цаашид хүсэлт гэх/-ийг Хил хамгаалах байгууллагаас дараах хууль, журмын зохицуулалтын хүрээнд шийдвэрлэж, хариу өгдөг байна. Үүнд:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж заасны дагуу Улсын хил нэвтэрсэн тухай лавлагаа нь “Хязгаарлалттай” мэдээллийн жагсаалтад хамаардаг.
- ХЗДХ-ийн Сайдын 2017 оны 12 дугаар сарын 21-ний А/295 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн санг ашиглах, мэдээлэл харилцан солилцох журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2-т Цахим системийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэгч байгууллага нь дор дурдсан үүрэг хүлээнэ. Мөн зүйлийн 6.2.4-т Цахим системд өөрийн бүрдүүлсэн мэдээллийн нэгдсэн сангаас холбогдох хууль тогтоомжийн дагуу лавлагаа, мэдээллийг олгоно.

- ХЗДХ-ийн Сайдын 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Улсын хилээр нэвтэрсэн зорчигч тээврийн хэрэгслийн мэдээлэл, лавлагаа өгөх журам”-ыг үндэслэн лавлагаа, мэдээллийг хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан, иргэнд эсхүл түүнтэй хамаарал бүхий хууль ёсны этгээдэд мөн түүнийг төлөөлөх эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчид хууль тогтоомжид заасан журмын дагуу өгнө гэж журамласныг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажилладаг байна.

Хүснэгт 3. Хил хамгаалах байгууллагын 2020-2022 оны 12 сарын 06-ны өдрийн байдлаар Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн талаар гаргаж өгсөн лавлагаа, мэдээллийн тоо

№	Он	Тээврийн хэрэгслийн лавлагаа	Зорчигчийн лавлагаа	Нийт
1	2020 он	1801	19005	20806
2	2021 он	414	13656	14070
3	2022 он	551	18433	18984

Дээрх тоон мэдээллээс харахад эрх бүхий байгууллага, иргэдийн Хил хамгаалах байгууллагад ирүүлсэн хүсэлтийн дагуу 2020 онд Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн талаар 20806, 2021 онд 14070, 2022 онд 18984 лавлагаа, мэдээлэл гаргаж өгсөн нь өссөн үзүүлэлттэй тухайн үйлчилгээ нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна.


Шигтгээ

Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн талаарх мэдээлэл, лавлагаа авах үйлчлүүлэгчийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа учир цаашид цахим болгох зайлшгүй шаардлагатай байгаа. Тухайлбал, Иргэнд хилийн хориг тавьж байгаа байгууллага нь мэдээллээ цахимаар өөрсдөө оруулдаг болох нь нэн тэргүүний ажил. Олон төрлийн албан бичиг төлөвлөж, холбогдох байгууллагуудад илгээх, шуудангийн болон бусад зардлыг технологийн дэвшлийг ашигласнаар буурч байгаа үүнийг бид энэ лавлагаа, мэдээллийн үйлчилгээндээ нэвтрүүлэх нь чухал юм.

Хил хамгаалах ерөнхий газрын алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Төрийн үйлчилгээний E-Mongolia нэгдсэн системд хандсан 88 иргэний улсын хилээр нэвтэрсэн талаарх лавлагаа, мэдээллийг гаргаж өгсөн нь цаашид иргэн, аж ахуйн нэгж оршин буй газар орноос үл хамаарсан үйлчилгээний чанар, түргэн шуурхай байдлыг давуу тал болгон, үйлчилгээний шинэлэг эрэлтийг бий болгож байна гэж дүгнэж болох юм.

Зураг 6. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аас Улсын хилээр нэвтэрсэн иргэний лавлагаа авах үйлчилгээ



Хилийн зурвас бүсэд ажиллах иргэд, компаниудад нийт 2225 зөвшөөрлийг бүртгэлээр хүлээлгэн өгчээ.

1.2.2. Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ

Хилийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт Хилийн боомт нь агаарын замын, төмөр замын, авто замын гэсэн төрөлтэй, байнгын, түр гэсэн горимтой, олон улсын, хоёр талын гэсэн зэрэглэлтэй байна гэж хуульчилсны дагуу Монгол Улс агаарын замын 1, төмөр замын 3, авто замын 17 гэсэн төрөлтэй 21 боомт, байнгын, түр, олон улсын, хоёр талын гэсэн зэрэглэлтэй боомт ажилладаг байна. Эдгээр боомтоос судалгааны баг байнгын ажиллагаатай авто замын Алтанбулаг, агаарын замын Чингис хаан боомтыг судалгааны түүвэрт хамруулан үйлчлүүлэгч (иргэн, хуулийн этгээд), хил хамгаалах байгууллагын алба хаагчаас асуулга болон ярилцлагын аргаар судалгаа авч хилийн боомтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд зохих үнэлгээ өгч ажилласан болно.

Хилийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт Хилийн боомтын төрөл, горим, зэрэглэлийг Засгийн газар тогтооно гэж заасны дагуу Засгийн газрын 2002 оны 212 дугаар тогтоолоор “Хилийн боомтуудын талаар баримтлах үйл ажиллагааны чиглэл”-ийг баталж, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хэтийн төлөв, улс хоорондын болон дотоодын бүх төрлийн замын сүлжээ, Мянганы замын гол гарцууд, чөлөөт бүсийн байршилтай уялдуулан, дэд бүтцийн салбарын хөгжлийн ойрын болон хэтийн зорилт, хилийн бүсийн орон нутгийн ашиг сонирхол, хилийн боомтуудын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг харгалзан шинээр хилийн боомт нээх, хаах, хөрш орнуудтай байгуулсан хэлэлцээрээр нэгэнт тогтоосон боомтуудын үйл ажиллагааг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.18-д Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн боомтуудын жишигт хүргэнэ. Хилийн заставуудын барилга, объектуудыг шинэчилж чанарыг сайжруулна гэж тусгасны дагуу Алтанбулаг боомтын барилгын ажлыг эхлүүлсэн хэдий ч байгаль, нийгэм, эдийн засгийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр ажлыг явц удаашралтай байгааг болон үйлчилгээ үзүүлж буй байр талбайг харна уу.

Зураг 7. Алтанбулаг боомтын барилгын ажлын явц 2022.12.16



Зураг 8. Алтанбулаг чөлөөт бүс дэх хилийн шалган нэвтрүүлэх хэсэг 2022.12.17



Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын 2.1.3-т улсын хилийн бүс, зурвас, боомт газарт орчин үеийн шаардлагад нийцсэн холбоо, хяналт, дохиолол, зам, тээвэр, инженерийн байгууламж бүхий хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлэх гэж тусгасны дагуу Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2021)-ийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор хил хамгаалах байгууллага улсын хилээр нэвтэрч байгаа гадаадын иргэнийг таних, баталгаажуулах зорилгоор биометрик мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбогдуулан техник технологийн дэвшилд нийцүүлэн хилийн программ хангамжийн хөгжүүлэлтийг 2022 онд тэргүүлэх ажил үйлчилгээнд тодорхойлон хэрэгжүүлсэн нь хилийн шалган нэвтрүүлэх болон боомтын үйлчилгээ авч буй иргэдийн хувьд 20-25 секунд, гадаад иргэдийн хувьд 30-40 секундийг нэг хүний үйлчилгээнд дунджаар зарцуулдаг байна.

Зураг 9. Алтанбулаг боомтын үйлчилгээний талбай 2022.12.16



Зураг 10. Алтанбулаг боомтын зорчигч шалган нэвтрүүлэх хэсэг 2022.12.17



Судалгаанд үнэлгээ хийхээр сонгон ажилласан олон улсын зэрэглэлтэй Агаарын замын Чингис хаан боомт нь олон улсын нислэгийн хуваарийн дагуу байнгын ажиллагаатай, хоёр улсын авто замын Алтанбулаг боомт нь 24 цагийн байнгын ажиллагаатай, хүн тээврийн хэрэгслийг Хилийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хилийн боомт, түүнд мөрдөх журмын дагуу шалган нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан ажилладаг байна.

Шигтгээ

Улсын хил хамгаалах байгууллага нь Үндсэн хууль, Хилийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, дэг журмыг сахиулах зорилгоор боомтод мөрдөх журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хилийн хяналтын байгууллага болох Гааль, Гадаадын иргэн, харьяатын газартай үйл ажиллагаагаа уялдуулан албан үүргээ гүйцэтгэдэг. Хилийн боомтод мөрдөх журам нь зорчигч, тээврийн хэрэгслийг хяналт шалгалтад оруулах, гаргах, тээврийн хэрэгслийг зогсоолд зогсоох, журам сахиулах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээнээс бүрдэх бөгөөд хил хамгаалах байгууллагын голлох чиг үүрэгт улсын хил зөрчигчийг илрүүлэх явдал юм. Зарим иргэд, олон нийт хилийн хяналтын байгууллагын чиг үүргийг хооронд нь хольж буруу ойлгох, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулах тохиолдол цөөнгүй гардаг боловч, бид иргэд, аж ахуйн нэгжид зохих мэдээлэл, тайлбар, зөвлөгөөг тухай бүрт нь өгч ажиллаж байна. Алтанбулаг боомтын өргөтгөл шинэчлэлийн ажил 2020 оны 8 дугаар сараас хийж эхэлсэн бөгөөд боомт бүрэн засварын үйл ажиллагаа явагдаж байгаа учир боомтын үйл ажиллагааг чөлөөт бүсийн 1 байрыг ашиглан түр горимоор зорчигч, тээврийн үйл ажиллагааг зориулалтын бус зам, талбай, ажилчдын ажиллах орчин нөхцөл нь жижиг талбайд явагдаж байгаа нь хүндрэлтэй байгаа гэсэн хэдий ч үндсэн чиг үүргээ хэвийн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хилийн боомтын алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Авто замын байнгын ажиллагаатай боомтын голлох хяналт шалгалтыг хүн, тээврийн хэрэгсэлд хийх хяналт шалгалт эзлэх бөгөөд Хилийн боомтод мөрдөх журмын дагуу шалгалт хийж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл, байрлалыг өөрчлөх, зорчигчийг суулгах, буулгахад хил хамгаалах байгууллагын алба хаагчийг зөвшөөрлөөр гүйцэтгэх бөгөөд шалгуулсан тээврийн хэрэгсэлд гаднын хүн зорчихыг хориглоно.

Хилийн боомтод үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, нэвтрэх үнэмлэхийг Хилийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9 дэх хэсэгт заасны дагуу олгодог байна. ХХЕГ-ын Хилийн боомтын аюулгүй байдал шалган нэвтрүүлэх газар (2022.12.12)-ын мэдээнээс

Хүснэгт 4. Хилийн боомтод үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагад олгосон зөвшөөрөл нэвтрэх үнэмлэхийн судалгаа

№	Боомтын төрөл	Зөвшөөрлийн төрөл	2020	2021	2022	Нийт	Тайлбар
1	Авто замын боомт	Худалдаа	13	1	2	16	Татваргүй барааны дэлгүүр, кофе шоп
		Үйлчилгээ	107	35	38	180	Гаалийн зуучлал, Банкны үйлчилгээ
		Бусад	7	17	15	39	Боомттой танилцах, барилгын зураг төсөл, замын өргөтгөл засвар, тоног төхөөрөмж суурилуулалт
2	Төмөр замын боомт	Худалдаа	-			-	
		Үйлчилгээ	1			1	Гаалийн зуучлал
		Бусад	-			-	
3	Агаарын замын боомт	Худалдаа	26	36	23	85	Татваргүй барааны дэлгүүр, кофе шоп
		Үйлчилгээ	1	1	0	2	Бизнес танхим, цэвэрлэгээ үйлчилгээ

	Хилийн бүсэд нэвтрэх үнэмлэх	2475	2716	1273	6464	Хилийн хяналтын байгууллагын ажилтан, алба хаагч
	Бусад	-	7	5	12	Олон улсын тээвэр логистик, судалгаа авах, цэвэрлэгээ үйлчилгээ
Нийт		2630	2813	1356	6799	

Шигтгээ

Хил хамгаалах байгууллага авто, төмөр, агаарын замын боомтод үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, ажилтанд хилийн боомтод нэвтрэх зөвшөөрөл олгодог. Дэлхий нийтийн хамарсан Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Чингис хаан боомтоос бусад хилийн боомтоор улсын хил нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон шийдвэрийг Засгийн газрын тогтоолоор баталж, Монгол, ОХУ-ын хилийн боомтоос Авто замын Алтанбулаг боомтыг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хэвийн горимоор ажиллуулж байна. Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах баг бүрэлдэхүүнийг тусгай хэрэгсэл техникээр хангаж, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ажил үйлчилгээ бүрэн хэрэгжүүлсэн үзүүлэлттэй байна. Монгол, БНХАУ-ын хилийн зорчигч тээврийн авто, төмөр замын боомт нээгдээгүй, байгаа хэдий ч боомт нээхэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг найдвартай хангах чиглэлд анхааран бэлтгэл ажлыг бүрэн хангаад байна. Хил хамгаалах байгууллагаас үл хамаарах хязгаарлагдмал нөөц зохион байгуулалтаас үйлдэлтэй ажил үйлчилгээ хойшилсон зүйл байгаа бөгөөд Алтанбулагийн хилийн боомтын барилга байгууламж ашиглалтад ороогүй, үйлчлүүлэгч, ажилтан алба хаагчийн ажиллах, хяналт шалгалт явуулах нөхцөл хангалтгүй байгаа.

Хил хамгаалах ерөнхий газрын алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Алтанбулаг чөлөөт бүс, Хөшигийн хөндийн Чингис хаан олон улсын нисэх буудалд байрлан үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажилтанд 1 жилийн хугацаатай хилийн боомтод нэвтрэх зөвшөөрөл олгох бөгөөд хилийн боомтын журам зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгодог байна.

Шигтгээ

Хуулийн дагуу боомтод нэвтрэх зөвшөөрөл авч ажил үйлчилгээ эрхэлж буй байгууллагын хувьд Хил хамгаалах байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ хурдан шуурхай байдаг. Боомтын цагийн хуваарийн дагуу ажиллаж, амардаг. Анх удаа ирж үйлчилгээ авч буй иргэдийн хувьд мэдээлэл дутмагаас болж, хил хамгаалах байгууллагын ажил үйлчилгээнд хүндрэл учруулах тохиолдол гаргадаг. Энэ нь хувь хүн байгууллагатай холбоотой гэж хөндлөнгийн ажиглагчийн зүгээс хардаг. Хил хамгаалах байгууллагын үйлчилгээ хүртээмжтэй түргэн шуурхай болж байгаа нь байнгын үйлчлүүлэгчид бидэнд бол мэдэгдэхүйц сайжирсан гэж үнэлж байна.

Авто замын хилийн боомтод ажил үйлчилгээ эрхэлж буй байгууллагын ажилтны ярилцлагаас

Монгол Улсын Үндсэн хууль, Хилийн тухай хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл журамд нийцүүлэн баталсан хилийн боомтод мөрдөх журмын хэрэгжилтийг хангах, боомтын аюулгүй байдлыг бэхжүүлэх зэрэг эрх зүйн орчны үр нөлөөлөлд дүн шинжилгээ хийхэд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасан ажил үйлчилгээний биелэлт дүгнэлттэй танилцах, эшлэх боломж хомс байгууллагын нууцын зэрэглэлтэй гэсэн тайлбар өгч байсныг хүндэтгэн үзсэнээ тэмдэглэж байна.

1.2.3. Хилийн зурваст нэвтрэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ

Хилийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт “Хилийн зурвас, боомт, бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг улсын хил хамгаалах байгууллагын дарга батална” гэж заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2017 оны А/97

дугаар тушаалаар “Улсын хилийн зурвас, боомт, бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг баталж, Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дах хэсэгт заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын бүртгэлд 2017 оны 3716 дугаарт бүртгүүлэн мөрдөж байна.

Хилийн зурвас, боомт, бүсэд нэвтрэх зөвшөөрлийн талаарх мэдээллийг Хил хамгаалах байгууллагын вэбсайт (www.bpo.gov.mn)-т байрлуулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бичгээр болон Төрийн үйлчилгээний бүртгэл хяналтын E-Mongolia системээр материалыг хүлээн авч, бүрдүүлэлтийг хянан ажлын 3 хоногт шийдвэрлэдэг байна.

Хилийн 14 аймгийн 77 сумдын хил орчмын нутаг дэвсгэрт ажил үйлчилгээ эрхлэх, аялал, жуулчлал, нислэг үйлдэх, эрдэм шинжилгээ-судалгаа хийх, байгалийн баялаг ашиглах, хадлан, тэжээл бэлтгэх, хилийн зурваст мал оторлох, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нэвтрэх зэрэг зорилгоор иргэн өргөдлөөр, аж ахуйн нэгж, байгууллага албан бичгээр Хил хамгаалах ерөнхий газар болон тухайн орон нутагт байрлах хилийн ангид гаргаж, давхардсан тоогоор 2183 аж ахуйн нэгж, байгууллага, 71025 иргэн, 37443 тээврийн хэрэгсэлд хилийн зурвас, бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгож, хил орчмын дэглэмийн биелэлтэд хяналт тавин ажилласан байна. Хил хамгаалах ерөнхий газраас олгох нэвтрэх зөвшөөрлийг хугацаа 1 жил, хилийн анги 30 хоног хүртэл хугацаагаар шаардлагатай тохиолдолд хугацааг сунгаж олгодог байна. Хил хамгаалах ерөнхий газрын байгууллагын вэб сайт (www.bpo.gov.mn)-т Хилийн бүс, зурваст нэвтрэх зөвшөөрлийг хүссэн иргэн, албан байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын бүрдүүлэх материалын жагсаалтыг холбогдох журмаас эш татаж, хилийн бүс, зурвас, боомтод нэвтрэх зөвшөөрлийн талаар мэдээлэл авах дугаарыг байршуулсан байна.

Шигтгээ

Хил хамгаалах байгууллагын шалган нэвтрүүлэх хэлтсээс ДХИС-ийн Хилийн албаны сургуультай хамтран хилийн шалгагч бэлтгэх 45 хоногийн дамжаа хичээллүүлж хүний нөөцийн бүрдүүлэлт хийж байна. Алба хаагчийн мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг улиралд хэлэлцүүлэг хэлбэрээр болон алба хаагчдаас сургагч багш бэлтгэн сургалт зохион байгуулж, туршлага солилцуулан ажиллаж байна. Манай байгууллага 2021 онд хилийн бүх боомтын шалгалтын техник хэрэгслийг шинэчилж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн. 2023 онд Цахим гарцыг Олон улсын агаарын замын Чингис хаан боомтод суурилуулахаар бэлтгэл ажил хангагдаж байна. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр хүлээлт, дугаарлалт байхгүй болно гэж тооцоолсон.

*Хил хамгаалах ерөнхий газрын алба
хаагчтай хийсэн ярилцлагаас*

“Улсын хилийн зурвас, боомт, бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын 2.4 дэх хэсэгт Хилийн зурвас, хилийн боомт, хилийн бүсэд нэвтэрсэн зөвшөөрөл олгосон байдлыг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн алба, хилийн төлөөлөгчийн газрын тайлан мэдээнд:

-Хилийн зурваст¹ 1735 аж ахуйн нэгж, байгууллага, 57274 иргэн, 33481 тээврийн хэрэгсэл;

-Хилийн бүсэд² 448 аж ахуйн нэгж, байгууллага, 13751 иргэн, 3962 тээврийн хэрэгсэлд түр нэвтрэх зөвшөөрөл тус тус олгосон байна.

¹ Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ. Хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг.

² Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн бүс гэх бөгөөд түүний өргөнийг улсын хил хамгаалах байгууллага тухайн нэгжсийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр улсын хилийн шугамаас 100 км-ээс илүүгүйгээр тогтооно. Хилийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг.

Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2017 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Шалган нэвтрүүлэх албаны үйлчилгээний стандарт батлах тухай”-ыг алба хаагч үйл ажиллагаандаа мөрдөж, хэвшүүлэн албаны гадаад төрх, хувцаслалт, харилцааны хэм хэмжээнд нийцүүлэн албан үүргээ гүйцэтгэдэг байна.

Шигтгээ

Чөлөөт бүсийн байранд хил хамгаалах байгууллага, гаалийн байгууллага үйлчилгээ үзүүлдэг бөгөөд байнгын ажиллагааны тус боомтын ажиллах орчин нөхцөл тааруу ариун цэврийн өрөө хангалтгүй, хүйтний улиралд алба хаагчид нь гадуур хувцастайгаа үйлчилж байгаа нь байрны хүйтэнтэй холбоотой байх гэж харж байна. Байнга хилийн боомт, зурваст нэвтэрч ажил эрхэлдэг тул боомтын барилга байгууламжийг нэн даруй ашиглалтад оруулах шаардлагатай хэдхэн алхмын цаана ажиллаж байгаа ОХУ-ын боомтын барилга байшинтай харьцуулаад үзэх хэрэгтэй. Харин манай хилийн байгууллагын үйлчилгээ түргэн шуурхай, хүнд сурталгүй байдагт талархалтай байдаг.

Авто замын хилийн боомтоор үйлчлүүлэгч иргэний төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Хилийн шалган нэвтрүүлэх албаны үйлчилгээний стандартыг батлан нэвтрүүлснээр хил хамгаалах байгууллагын ажил үйлчилгээнд бодитой ахиц, өөрчлөлт гарсан гэж алба хаагчид судалгааны явцад илэрхийлсэн бөгөөд харин үйлчлүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн хувьд үйлчилгээ үзүүлж буй зай талбай жижиг хүн хоорондын зай барих боломж муу, ариун цэврийн өрөө хүрэлцээгүй зэрэг дэд бүтэцтэй холбоотой санал хүсэлтийг судалгааны явцад илэрхийлсэн болно.

Хоёр. ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА

2.1. Алба хаагчийн ажиллах нөхцөл, нийгэм, эдийн засгийн баталгаа

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно гэсэн суурь хэм хэмжээний хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, 62 дугаар зүйлд Төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хуульчилсан Хил хамгаалах байгууллагын ажилтан, алба хаагч нь төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалыг ангилалд, удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлд хамааран хамаардаг ажил алба эрхэлдэг байна. Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд Хилчин, улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа иргэний эрх зүйн баталгааг хангах чиг үүргийн Засгийн газар хэрэгжүүлэх бөгөөд энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэх, нөөцийг тодорхойлсон Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичгийн Зорилт 7.2-т Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг ханган хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлэн уг Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн I үе шат (2021-2030): Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх үе. Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын 2.2.7-д хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагуудыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангах, тэдгээрийн нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, тэдний ар гэрийн нийгмийн баталгааг бодитойгоор дэмжих, тус бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүн, хүч, хөрөнгийн тооцоог гаргаж, жил бүрийн төвлөрсөн болон орон нутгийн төсөв бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх шаардлагатай гэж тусгасан бөгөөд хил хамгаалах байгууллагын ажилтан, алба хаагчийн ажиллах нөхцөл, нийгэм, эдийн засгийн баталгааг хангах эрх зүйн орчин хангалттай бэхэжсэн байх бөгөөд дээр дурдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хил хамгаалах байгууллага 2022 онд ажилтан, алба хаагчийн ажиллах нөхцөл, орон байрны хүртээмжид анхаарч ажилласан гэж тайландаа дурдсан байна.

Зарим хэрэгжүүлсэн ажлаас хэрэглэгчийн үнэлгээнд шалгуур үзүүлэлтээр харгалзан үзэх боломжтой Хилчдийн өрхийн орлогыг нэмэгдүүлж, хувийн эзэмшлийн газар орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлж, гэр бүлийн гишүүдийн хөгжлийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажилд:

-Алба хаагчдын гэр бүлийн гишүүдийг мэргэшүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн мэргэжил сургалтын төвд суралцах хүсэлтэй нийгмийн даатгал төлдөггүй гэр бүлийн 25 гишүүнийг 6 сарын хугацаатай, цалинтай мэргэжил олгох сургалтад хамруулж, Хилийн цэргийн ... дүгээр анги оёдлын цехийн өрөөг төхөөрөмжлөн, үйл ажиллагааг эхлүүлсэн ба алба хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн хэрэглээний хувцас хэрэглэлийг үнэ төлбөргүй оёж, захиалгат үйлчилгээ эрхэлж өрхийн орлогыг 3.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

- Боловсрол, соёл шинжлэх ухааны яаманд хилийн цэргийн ... дугаар ангийн салбарт гэр цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээг ажиллуулахад дэмжлэг үзүүлэх талаарх албан бичгийг хүргүүлэн, 2023 онд шийдвэрлэх урсгал зардлын 15 сая төгрөгийн зардлыг мөн ажилтан, алба хаагчийн хүүхдийн нэгдсэн судалгааг гаргаж, байгууллагын

удирдлагад танилцуулан, 2023 онд байгууллагын дэргэдэх цэцэрлэг, хүүхэд харах өрөөг тохижуулах талаарх санал гаргаж төсвийг тус тус шийдвэрлүүлжээ.

Шигтгээ

Байнгын ажиллагаатай авто замын боомтод үүрэг гүйцэтгэж буй алба хаагчийн ар гэр тэр дундаа хүүхэд хараа хяналтгүй, хүүхдийг хүүхдээр харуулах нөхцөл байдал ганц манайд гэлтгүй бүх л хилийн ангид тулгамдаж буй асуудлын нэг, манай ангийн хувьд хүүхэд харах үйлчилгээг ажлын цагаар хэрэгжүүлж эхэлсэн нь ангид ажиллаж байгаа ажилтан, алба хаагчийн хувьд давуу тал болж байгаа ч ээлжийн ажил эрхэлж буй алба хаагчийн хувьд шийдвэрлэгдээгүй асуудал хэвээр байна. Мөн хил хамгаалах байгууллагын алба хаагч улсынхаа аль ч хил хязгаарт ажиллах үүрэг хүлээсэн томилгооны дагуу ажилладаг эдгээр алба хаагчийн хүүхдийн боловсрол хоцрогдол их байхын зэрэгцээ ерөнхий боловсролын зарим сургууль тухайн хүүхдийг олон сургууль шилжсэн, шалгалт авч шилжүүлэн суралцуулна гэж үзэмжээр хандаж байгаад алба хаагчид гомдолтой байдаг.

Хилийн боомтын алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Энэ нь төрийн байгууллагын уялдаа холбоо, онцлогийг харгалзан үзэж дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах тал дээр дутмагшилтай байгааг харуулж байна.

Шигтгээ

Боомтын барилгын өргөтгөл шинэчлэлтэй холбоотой шалган нэвтрүүлэх байрны орчин нөхцөл нь үүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй өвлийн улиралд зорчигчийн нэвтрэлтээс шалтгаалан дулааны алдалт их тул халаалтын асуудал хүнд байна. Тень залгахаар цахилгааны хүчдэл дийлэхгүй тул гадуур хувцастай өрөөнд үүрэг гүйцэтгэх тохиолдол гарч байна. Аймагас энэхүү цахилгааны асуудлыг шийдвэрлэхээр болсон боловч одоогоор шийдвэрлээгүй байна. Түр амрах болон хооллох байр гэж түр горимоор ажиллаж буй байрны багтаамж хүрэлцээнээс хамаарч гадна жижиг вагончик маягийн төмөр байранд байрлаж байгаа ба энэ мөн хүйтэн байна. Түр горимоор байрлаж буй байранд ариун цэврийн өрөөгөөр зорчигч болон манай байгууллага, гааль, гадаадын харьяатын алба хаагч нар үйлчлүүлж байгаа нь хүрэлцээ хангалтгүй байдалтай байна.

Хилийн боомтын алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Хил хамгаалах байгууллагад ажиллаж буй алба хаагчийн шилжилт хөдөлгөөнд дүн шинжилгээ хийж, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт заасан Цалин хөлсний бүрдэл, төрийн бусад тусгай чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчийн цалингийн шатлал зэрэгт харьцуулалт хийж, эдийн засгийн баталгааг бэхжүүлэх хэрэгцээ шаардлага буйг судалгааны баг зүгээс тэмдэглэж байна. Түүнчлэн хил хамгаалах байгууллагын түвшинд хэд хэдэн социологийн судалгаа авсан талаар тайланд дурдсан хэдий ч судалгаагаар илэрсэн сайжруулах шаардлагатай ажил үйлчилгээг нэгтгэлгүй орхигдуулсан зэрэг дутагдал ажиглагдлаа.

Шигтгээ

Алба хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар анхаарал хандуулах хэрэгтэй бөгөөд бусад тусгай чиг үүргийн байгууллагыг бодвол манай хил хамгаалах байгууллагын алба хаагчдын цалин хөлс бага байгааг судалгаанаас олж харсан. Энэ нь ч хил хамгаалах байгууллагаас сүүлийн үед алба хаагч нар гарах гол шалтгаан гэж хардаг. Иймд алба хаагчдын цалин хөлснийг нэмэгдүүлснээр алба хаагч, ажилтан ажилдаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэх болов уу. Хангалт хангамжийн хувьд тухайлбал хоол хүнсний болон дүрэмт хувцасны хангалтыг ХХЕГ-аас төсөвлөсөн төсвөөс нормт хэмжээ, хугацаагаар тухай бүрт хангалттай олгож байна. Хилийн ... дүгээр анги нь өөрийн харьяанд мал аж ахуйтай учир мал мах бэлтгэх ажлаа өөрсдөө хариуцан хийж байна. Тухайн анги албаны байр орон сууцны хувьд бусад боомтод байрлах хилийн ангитай харьцуулахад боломж бололцоо муу учир дутагдалтай бөгөөд манай ангийн алба хаагчдын 5 хувьд албаны байраар хангах боломжтой ба түүндээ шинээр томилогдон ирсэн алба хаагчдыг 1 жил хүртэл хугацаанд байрлуулж алба хаагчийг ажилдаа дасан зохицох нөхцөл бололцоогоор хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Хилийн боомтын алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Хил хамгаалах байгууллагын ажилтан, алба хаагчийн ажиллах нөхцөл, нийгэм, эдийн засгийн баталгааг хангах чиглэлийг төлөвлөгөөт ажлыг үе шаттай хэрэгжүүлэхийн зэрэгцээ дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндэд учирсан нөлөөллийг бууруулах, сэргээн засах

эмчилгээ үйлчилгээнд 2022 онд алба хаагчдыг зохих түвшинд хамруулан ажилласан талаар тайлан мэдээнд дурдсаныг ярилцлагын судалгаанд хөндөгдсөн зарим цаашид анхаарвал зохих, ажил хэрэг болгохуйц санал санаачилгатай хамтатган үнэлж үзлээ. Тайлант хугацаанд Хил хамгаалах байгууллагаас гаргасан төлөвлөгөөний дагуу цэргийн анги, тусгай салбарууд аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран 11779 албан хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, төрийн эрүүл мэндийн байгууллагын цахим мэдээллийн сан Н-info программыг бүрэн ашиглаж, бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн мэдээ, тайланг сар бүр орон нутгийн Эрүүл мэндийн газарт илгээж, мэдээллийн санд баяжилт хийсэн байна. Хилийн цэргийн ... дүгээр ангиудын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд эмийн ургамлыг эмийн бус эмчилгээнд хэрхэн ашиглах, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар хамтарсан сургалт зохион байгуулан, физик эмчилгээний шинэ тоног төхөөрөмж худалдан авч ашиглаж байна. Хилийн цэргийн ... дугаар ангийн эрүүл мэндийн төвийн анхан шатны тусламж үйлчилгээний бэлэн байдал хангалттай хэдий ч эм, эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн хангалт үйлчилгээ, эмч, ажилтныг мэргэшүүлэх зэрэгт цаашид аймгийн эрүүл мэндийн төв, бүсийн оношилгооны нэгдсэн төвтэй хамтран ажиллах талаар бодлогын түвшинд анхаарч ажиллах нь шаардлагатай гэж үзэж байна.

Хилийн цэргийн ... дүгээр ангиуд нийслэлийн дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, алба хаагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, артерийн даралт ихсэлт, цусан дахь сахрын хэмжээ, хавдрын эрт илрүүлгийн 5 төрлийн лабораторийн шинжилгээнд хамруулан ажилласан гэжээ.

Шигтгээ

Эрүүл мэндийн эрт илрүүлэг оношилгоонд хил хамгаалах байгууллагын ажилтан алба хаагчдыг бүрэн хамруулах төлөвлөгөөт ажил зохион байгуулах үед ээлжийн ажилтай алба хаагчид эрүүл мэндийн байгууллагын олгосон хуваарьт цагт орж чадалгүй хоцорсон бөгөөд ээлжээс буугаад хамрагдах гэсэн боловч хугацаандаа хамрагдаагүй гэж хойшлуулаад одоог хүртэл хамрагдах боломжгүй байна. Энэ нь ганц манай байгууллагаар зогсохгүй тусгай чиг үүрэг хэрэгжүүлж буй бүх л байгууллагын алба хаагчдад тулгамдаж байгаа тул эрүүл мэндийн байгууллагатай ажлын нөхцөл байдлаас хамаарсан зохицуулалт хийх боломжийг судалж хамтран ажиллах хэрэгтэй байна.

Хилийн боомтын алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Хилийн цэргийн 14 ангийн алба хаагчдаас хилийн ангиудын харьяа амралт сувиллын газарт ковидын дараах нөхөн сэргээх эмчилгээ сувилгаанд хамруулан эрүүл мэндийг дэмжих ажил зохион байгуулсан байна. Тайлант хугацаанд хийж хэрэгжүүлсэн эрүүл мэндийн чиглэлийн олон ажил үйлчилгээнээс голлон анхаарал хандуулах судалгаанд дүгнэлт болох хэсгийг эш татсанаа дурдаж байна. Цаашид хилчид тэдгээрийн гэр бүлийн эрүүл мэндийг хамгаалах ажил үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд орон нутгийн байгууллагын дэмжлэг туслалцаа хамтын ажиллагаа чухал болохыг онцлон тэмдэглэж байна.

2.2. ХХЕГ өмнөх хэрэглэгчийн үнэлгээний мөрөөр үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тойм

Өмнөх жилийн хэрэглэгчийн үнэлгээний судалгааны дүгнэлтэд тус байгууллагын хэрэглэгчдийн үнэлгээ маш сайн буюу 96.9 хувьтай 4.8 оноогоор дүгнэгдсэн байна. Энэ жил тус байгууллагын нийт үзүүлэлт 95.8 хувь буюу 4.79 оноогоор үнэлэгдсэн байна. Энэхүү ялимгүй бага зөрүү нь байгууллагын үйл ажиллагаа аливаа байдлаар муудсан эсвэл дордсон гэж үзэх үндэслэл болохгүй гэж дүгнэж байна.

Харин өмнөх жилийн буюу 2021 оны Хэрэглэгчийн үнэлгээний зөвлөмжид Хил хамгаалах байгууллагын алба хаагчдад чиглэсэн “Хилчдийн нийгмийн хамгаалал – 2024”

хөтөлбөрийг хэрэгжүүлж, алба хаагчдыг албаны байраар хангах, өөрийн орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх, ажлын байрын эрүүл, аюулгүй орчныг бий болгох, ажилтнуудын ажлын ачааллыг стандартын түвшинд ойртуулах талаар арга хэмжээ авч байгааг цаашид үргэлжлүүлэх, ХХБ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг төдийгүй хилийн боомтод үйл ажиллагаа явуулж буй хяналт шалгалтын байгууллагуудын хэрэгжүүлж буй чиг үүргийн онцлог, зааг ялгааг иргэдэд хүртээмжтэй, ил тод, ойлгомжтой байдлаар хүргэхэд анхаарч ажиллах нь зүйтэй гэж дүгнэсэн байна.

Тус байгууллага нь энэхүү зөвлөмжийн мөрөөр Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2015 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар батлагдсан “Хилчдийн нийгмийн хамгаалал-2024” хөтөлбөрийн хэрэгжилтийг улам төгөлдөржүүлж, тус хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдын болон ахмад хилчдийн эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг бүлэглэн ангилж ажилласан нь сайшаалтай байна. Тухайлбал хилчдийн нийгмийн хамгааллын холбогдолтой хууль, эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах замаар тэдний нийгмийн баталгааг сайжруулах, хилчдийн амралт, сувиллын газрыг нэмэгдүүлэн өвчлөлийг бууруулах, хилчдийн албаны ур чадвар, мэдлэг, боловсрол, хувь хүний хөгжлийг дэмжих, алба хаагчдын ажиллаж, амьдрах орчин, албаны орон сууцны хангалт, нөхцөлийг сайжруулах, ахмад хилчдийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, Хилчдийн өрхийн орлогыг нэмэгдүүлж, хувийн эзэмшлийн газар орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлж, гэр бүлийн гишүүдийн хөгжлийг сайжруулах чиглэлээр тус бүр арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжүүлсэн байна. Гэвч нийт 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээс “Хилийн цэргийн ангиудын Эрүүл мэндийн төвийн албанд хэрэглэгдэж буй эмийн бус эмчилгээ, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх, туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулах”, “Хил хамгаалах ерөнхий газрын болон Улаанбаатар хүрээний ангиудын албан хаагчдын хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулахад дэмжлэг үзүүлэх” гэсэн 2 заалтын хэрэгжилт бүрэн хангагдаагүй орхигдсон бөгөөд тус хөтөлбөрийн хэрэгжилтийг байгууллага нь 87,8 хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн байна.

Харин 2021 оны хэрэглэгчийн үнэлгээний зөвлөмжийн дагуу ХХБ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг төдийгүй хилийн боомтод үйл ажиллагаа явуулж буй хяналт шалгалтын байгууллагуудын хэрэгжүүлж буй чиг үүргийн онцлог, зааг ялгааг иргэдэд хүртээмжтэй, ил тод, ойлгомжтой байдлаар хүргэхэд чиглэсэн үйл ажиллагааг шууд авч хэрэгжүүлсэн тохиолдол илэрсэнгүй.

Хэдий тийм боловч цахим болон бусад хэлбэрээр иргэд, байгууллагуудад мэдээлэл хүргэх, цахим үйлчилгээ үзүүлэх чиглэлээр багагүй амжилт гаргасан байх тул өмнөх хэрэглэгчийн үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авсан гэж дүгнэж байна.

ДҮГНЭЛТ

Хил хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан тус байгууллагын зарим холбогдох мэдээлэл нь Төрийн болон албаны нууцын тухай хууль болон Нийтийн мэдээллийн тухай хуулийн зарим зохицуулалтууд, Монгол Улсын бусад хууль тогтоомжийн дагуу хязгаарлалттай болон хаалттай байсан учир судалгааны баг нь захиалагч байгууллагын гаргаж өгсөн мэдээллийн хүрээнд судлан шинжилж энэхүү судалгааны дүгнэлтийг боловсрууллаа.

Тус байгууллагаас эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр олон нийтэд чиглэсэн ажил үйлчилгээг тодорхой байдлаар хийж гүйцэтгэсэн байх боловч энэхүү нийгэмд чиглэсэн үйл ажиллагааны үр дүн дэвшүүлсэн зорилго, зорилгод хэрхэн хүрсэн эсэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг олон улсад болон дотоодод тайлбарлан таниулах, бусад орны туршлага судлахад эрдэм шинжилгээ судалгааны чиглэлд тодорхой агуулга бүхий олон улсын болон улсын чанартай эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулан шинжлэх ухааны үндэслэл онолын болон практик ач холбогдол, тулгамдсан асуудлын шийдвэрлэлт, шинэлэг арга зүйн талаар дүгнэлт хийж үр дүнг тооцон гаргасан зөвлөмжийн хэрэгжилт тодорхойгүй байдал ажиглагдаж байна.

Төрийн үйлчилгээний E-Mongolia нэгдсэн системд хандсан 88 иргэний улсын хилээр нэвтэрсэн талаарх лавлагаа, мэдээллийг гаргаж өгсөн нь цаашид иргэн, аж ахуйн нэгж оршин буй газар орноос үл хамаарсан үйлчилгээний чанар, түргэн шуурхай байдлыг давуу тал болгон, үйлчилгээний шинэлэг эрэлтийг бий болгож байна гэж дүгнэж болох юм.

Мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг хангах асуудлаар ХХЕГ нь шинэ санаачилга гарган амжилттай ажиллаж байгаа нь сайшаалтай. Цаашид тус байгууллагын үйл ажиллагааны талаар төрийн нууцад хамаарах болон ил тод байх мэдээллийн заагийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулж, вэбсайт дахь мэдээллийг илүү дэлгэрэнгүй болгох үндсэн шаардлага байгаа нь ажиглагдлаа.

Цаашид хилийн зурвас, бүсэд 2022 онд түр нэвтрэх зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллагын иргэний харьяалал, зорилго, хилийн бүсийн аль аймаг, сумын нутагт нэвтрэх зөвшөөрөл илүү олгогдсон зэрэг илүү нарийвчилсан байдлаар тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээг хийж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Судалгаанд хамрагдсан иргэд, ААНБ-ын төлөөлөл хилийн шалгагч нарын орон тоог нэмэх, үйлчилгээний заал, танхимын хүрэлцээ багтаамж, тохь тухын асуудлыг сайжруулах санал тавьж байв. ХШН боомтод иргэдтэй хамгийн их нүүр тулж ажилладаг хилийн шалгагч нарын хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээ, бичиг баримт шалгуулах \штамп дарах\, хилийн боомтоор үйлчлүүлэхэд ХХБ-ын үзүүлж буй үйлчилгээнээс шалтгаалсан чирэгдэл гардаггүй, түргэн шуурхай үйлчлүүлдэг гэж нийт судалгаанд оролцогчдын 95.6 хувь нь хариулснаас үзвэл иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж байна гэж дүгнэх үндэстэй. Үнэлгээнд хамрагдсан ААН байгууллагуудын ажилтнуудын үзэж байгаагаар хилийн зурваст үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад ХХБ-аас шалтгаалсан хүндрэл бэрхшээл тохиолддоггүй гэж дийлэнх нь буюу 85.7 хувь (22 байгууллага) нь хариулжээ.

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнгээс ерөнхийд нь авч үзвэл ХХБ-аар үйлчлүүлдэг иргэд, ААНБ, хамтран ажилладаг байгууллагууд ХХБ-ын хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээнд сэтгэл хангалуун гэж үнэлж байгаа ч ачаалал өндөртэй боомтуудад үйлчилгээ үзүүлж буй шалгагч нарын ёс зүй, харилцаа, хандлагыг илүү сайжруулах, харилцааны болон асуудал шийдвэрлэх ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, мөн үйлчилгээ үзүүлж буй орчин

нөхцөлийг тохижуулах шаардлагатай болохыг чанарын судалгааны явцад илэрхийлж байлаа. Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлын ХШН боомтод ХХБ-ын үйл ажиллагааг сурталчлан, таниулах шаардлагатай ба тус цэгээс үйлчилгээ авсан иргэдийн хувьд ХХБ-аас ямар үйлчилгээ авсан талаараа мэдэхгүй, ХХЕГ-ын талаар ойлголт, мэдлэггүй байна. Өмнөх 2021 оны хэрэглэгчийн үнэлгээний дүгнэлтэд ч мөн адил ХХБ-ын үйл ажиллагааны онцлогийг таниулан сурталчлах талаар зөвлөмж хүргүүлсэн байсныг тус байгууллага зөвхөн зарим байдлаар хэрэгжүүлсэн болохыг энд дурдах нь зүйтэй байна. Энэхүү 2022 оны судалгаанд ч мөн адил ХХЕГ-ын үйл ажиллагааны онцлог, ялгааг иргэдэд сурталчлах, ялангуяа ямар үндэслэлээр төрийн болон албаны аливаа нууцад хамаарч хязгаарлалттай эсвэл хаалттай мэдээллийн аль нь болох тухай мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэж тайлбарлах зөвлөмжийг хүргүүлж байгаа билээ.

Судалгааны хүрээнд ХХЕГ-ын үзүүлж буй үйлчилгээг 5 багц бүхий 25 дэд шалгуур үзүүлэлтийн дагуу 1-100 баллаар үнэлүүлж түүнийг 1-5 оноонд шилжүүлэхэд ХХЕГ-ын хэрэглэгчийн үнэлгээний дүн 95.8 хувь буюу 4.79 гарсан. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 5. ХХЕГ-ын хэрэглэгчийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тоон үр дүнг дүгнэсэн хувь, онооны үзүүлэлтүүд

		Хувь /1-100%/	Оноо /1-5/
1	Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлын үнэлгээ	97.7	4.89
2	Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	93.8	4.69
3	Алба хаагчийн ёс зүй, ур чадварын буй үнэлгээ	96.9	4.85
4	Үйлчилгээний шат дамжлага, түргэн шуурхай байдлын үнэлгээ	95.6	4.78
5	Үйлчилгээний хүртээмжтэй, ойлгомжтой байдлын үнэлгээ	95.4	4.77
6	Дундаж	95.8	4.79

ЗӨВЛӨМЖ

1. Эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр олон нийтэд чиглэсэн ажил үйлчилгээг сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн оюутан суралцагч, иргэд, аж ахуйн нэгжид сурталчлан, тайлбарлан таниулах, төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бусаар явуулсан урлаг соёлын үйл ажиллагааны үр дүн, нийгэмд үзүүлсэн нөлөөллийн өөрийн үнэлгээг тухай бүр дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх ажилдаа суурь үзүүлэлт болгон төлөвлөн гүйцэтгэхэд анхаарах;
2. Эрдэм шинжилгээ судалгааны чиглэлд тодорхой агуулга бүхий олон улсын болон улсын чанартай эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулан шинжлэх ухааны үндэслэл онолын болон практик ач холбогдол, тулгамдсан асуудлын шийдвэрлэлт, шинэлэг арга зүйн талаар дүгнэж үр дүнг тооцон гаргасан зөвлөмжийн талаар хийсэн ажил үйлчилгээний нийцлийн байдалд үнэлгээ дүгнэлтийг өгөхөд анхаарах;

3. Судалгааны дүнгээр ХШН боомтод ХХБ-аас үзүүлж буй үйлчилгээ бусад хил хяналтын байгууллагуудтай харьцуулахад түргэн шуурхай чирэгдэлгүй гэж үнэлсэн бол харин үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын харилцааны соёлтой холбоотой шүүмжлэлттэй асуудлыг хөндөж тавьсныг харгалзан шалгагч нар болон хилийн заставд ажиллаж байгаа албан хаагчдыг харилцааны ур чадвар, харилцааны соёлын сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд хамруулах;
4. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нь ямар үндэслэлээр төрийн болон албаны аливаа нууцад бүртгэгдсэн бөгөөд хязгаарлалттай эсвэл хаалттай мэдээллийн алинд нь хамаарч байгаа тухай мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэж тайлбарлах;
5. ХХЕГ-ын чиг үүрэг, түүх, хилийн боомтын бодлого, хил нэвтрэх тухай заавар зэрэг мэдээллийг нийгмийн сүлжээ, телевизийн сувгаар голчлон дамжуулах бөгөөд тодорхой боомтоос хамаарч үйлчлүүлж буй иргэд, байгууллагууд ялгаатай ойлголт мэдлэгтэй байгааг анхаарч мэдээллийн хүртээмжийг жигд сайжруулах;
6. Утсаар болон вэбсайтаар хүргэх мэдээллийн агуулгад анхаарч үйлчлүүлэгчдийн хүсэж байгаа мэдээллийг судлан тогтоох, хүргэх;
7. ХХБ-ын ажиллагсдын ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандартад заасан харилцааны соёлыг хэвшүүлэхэд анхаарах;
8. ХХБ чиг үүргийн хүрээнд иргэд, ААНБ, харилцагч байгууллагад үзүүлдэг үйлчилгээний талаар мэдээлэл өгдөг байх нь иргэдийн хил хяналтын байгууллагын талаарх тодорхой мэдээлэлтэй болох, аль байгууллага нь иргэдэд ямар үйлчилгээ үзүүлдэг, аль байгууллагад нь хүнд суртал, чирэгдэл үүсэж байгаа талаар зөв ойлголттой болох ач холбогдолтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Үндсэн хууль
2. Төрийн албаны хууль
3. Захиргааны ерөнхий хууль
4. Хөдөлмөрийн тухай хууль
5. Хилийн тухай хууль
6. Цэргийн албаны тухай хууль
7. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль
8. Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”
9. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг
10. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
11. Улсын хилийн зурвас, бүсэд түр нэвтрэх зөвшөөрөл олгосон тайлан, 2022 он
12. Хилийн цэргийн төв архивын тайлан, 2022 он
13. Хил хамгаалах ерөнхий газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, 2022 он
14. Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн талаар лавлагаа, мэдээллийн тайлан, 2022 он
15. “Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах 2022 оны ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 2022 он
16. Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2017 оны А/97 дугаар тушаалаар “Улсын хилийн зурвас, боомт, бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”
17. Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2022 оны А/205 дугаар тушаалаар баталсан “Ёс зүйн дүрэм”
18. Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2017 оны А/45 дугаар “Шалган нэвтрүүлэх албаны үйлчилгээний стандарт батлах тухай”